

САНГИЙН ЯАМ

2019-02-11

Улаанбаатар хот

ШАЛГАЛТЫН ТАЙЛАН

“Тариаланг дэмжих сан”-гийн
санхүүгийн үйл ажиллагаанд
хийсэн шалгалтын тухай

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Ерөнхий мэдээлэл

Сангийн Сайд Ч.Хүрэлбаатарын 2019 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу “Тариаланг дэмжих сан”-гийн үүсгэн байгуулагдсанаас хойшхи онуудын санхүүгийн үйл ажиллагаанд 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн ажлын 16 хоногт багтаан шалгалт хийв.

Хяналт шалгалтыг явуулахдаа “Төсвийн тухай”, “Төрийн хяналт, шалгалтын тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Засгийн газрын тусгай сангийн тухай” хууль тогтоомжууд, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан Засгийн газрын тогтоол, шийдвэр, журмын биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах зорилгоор шалгалтыг хяналт шалгалтын ерөнхий стандарт, журам, шаардлага, улсын байцаагчийн эрх үүргийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Энэхүү шалгалтанд тариаланг дэмжих сангийн баримталж ажилладаг хууль, тогтоомж, үйл ажиллагааны дүрэм, журмын нийцэл, худалдан авах ажиллагаа, санхүүгийн дэмжлэгийн олголт (зээл), эргэн төлөлт, буудайн урамшуулал олголт, авлагын суутган тооцоо, хугацаа хэтэрсэн өр, авлагын барагдуулалт, тоног төхөөрөмжийн борлуулалт, үйл ажиллагааны эрсдэл зэргийг хамруулан судалсан болно.

2. Тариаланг дэмжих сангийн эрх бүхий албан тушаалтнууд:

“Тариаланг дэмжих сан”-гийн шалгагдсан хугацааны санхүү, аж ахуйн үйл ажиллагааны баримтад гарын үсэг зурж, хөрөнгийг захиран зарцуулж ирсэн албан тушаалтнууд болон тухайн хугацаанд хамаарах төсвийн ерөнхийлөн захирагчийн талаарх мэдээллийг хүснэгтэд харуулав.

№	ХХААХҮ-ын сайд	Огноо	№	Сангийн захирал	Огноо
1	Д.Тэрбишдагва	2004.09-2007.12	1	Ч.Пэрэнлэй	2005.08-2007.12
2	Ц.Ганхуяг	2007.12-2008.09	2	М.Хүрэлсүх	2007.12-2008.05
3	Т.Бадамжунай	2008.09-2012.08	3	Л.Энх-Амгалан	2008.05-2008.08
			4	С.Хүрэлсүх	2008.08-2008.10
			5	Ц.Батсайхан	2008.10-2010.03
4	Х.Баттулга	2012.08-2014.06	6	Л.Дүйнхэржав	2010.03-2012.12
			7	Д.Од	2012.10-2014.06
5	Ш.Түвдэндорж	2014.06-2014.12	8	Б.Бат-Эрдэнэ	2014.06-2014.12
6	Р.Бурмаа	2014.12-2016.07	9	Н.Ариунболд	2014.12-2015.02
7	П.Сэргэлэн	2016.07-2017.10	10	М.Цолмон	2015.02-2016.03
8	Б.Батзориг	2017.10-2019.01	11	Б.Манансан	2016.03-2016.08
9	Ч.Улаан	2019.01-	12	В.Үнэнбат	2016.08-

Шалгалтын хамарсан хугацаа буюу 2005-2018 оны хоорондох 13 жилийн хугацаанд Тариаланг дэмжих сангийн захирал 12 удаа ерөнхий нягтлан бодогч 9 удаа өөрчлөгдсөн байна. Түүнчлэн, тус сангийн удирдах албан тушаалтнууд буюу хэлтсийн дарга нар нь гүйцэтгэх захирал солигдох тухай бүр дагаж өөрчлөгдөж байсан нь тус сангийн хүний нөөцийн бодлого, тогтвортой үйл ажиллагаа явуулахад сөргөөр нөлөөлж ирсэн байна.

3. Худалдан авах ажиллагааны талаар:

Тус сангийн үйл ажиллагаатай холбоотой дараах төрлийн худалдан авах ажиллагаануудыг Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон ХХААХҮЯ-наас зохион байгуулдаг байна.

Тариаланг дэмжих сангийн зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа:

- Үрийн буудай;
- Хүнсний буудай;
- Шатахуун;
- Ургамал хамгааллын бодис, бордоо

ХХААХҮЯ-аас зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа:

- Тариалан эрхлэлтийг дэмжих сангаар дамжуулан зээлдүүлэх хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжүүд /трактор, комбайн г.м./;
- Жимс, жимсгэний суулгац, хүлэмжийн тоног төхөөрөмж

Шалгалтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2009-2018 онд зохион байгуулсан тендер шалгаруулалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/ болон түүнийг дагалдаж гарсан журам зааврыг мөрдөж ажилласан эсэхийг ажлын хэсэгт гаргаж өгсөн 230 ширхэг хавтаст материалын хүрээнд хянан үзлээ. Хэдийгээр тендер шалгаруулалттай холбоотой

мэдээллүүдийг ХХААХҮЯ болон сангийн зүгээс гаргаж өгсөн боловч тендер шалгаруулалтад оролцсон боловч шалгараагүй ААН-үүдийн тендерийн баримт материалыг ажлын хэсэгт ирүүлээгүй болно.

Хавтаст материалаас үзэхэд тариалан эрхлэлтийг дэмжих зориулалтаар 2009-2018 онд нийт 138.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 115 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 118.7 тэрбум төгрөгийн дүнтэй гэрээг байгуулсан байна.

Нийт 115 тендер шалгаруулалтын хавтаст материалаас үзэхэд 50 тендер шалгаруулалтын үнэлгээ хууль, журамд нийцэхгүй байгааг илрүүлсэн болно.

I. ХХААХҮЯ-аас зохион байгуулсан худалдан авалтын талаар:

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам нь 2009-2012 оны хооронд тус сангийн худалдан авалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулдаг байсан бөгөөд 2012 оноос эхлэн шатахуун, ургамал хамгааллын бодис үрийн буудай, хүнсний буудайн худалдан авалтыг сан өөрөө хариуцан зохион байгуулдаг болсон байна. Тус яамнаас 2009-2018 оны хооронд нийт 60 удаагийн тендерийн сонгон шалгаруулалтыг хийж нийт 58.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээг нийлүүлэгч ААН-үүдтэй байгуулснаас нийт 30 тендер нь худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж хийгдсэн нь шалгалтаар тогтоогдсон.

ХХААХҮЯ-аас зохион байгуулсан тендерийн хураангуй мэдээ:

Он	Байгууллага	Тендер тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Зөрчилтэй тендерийн тоо	Зөрчилтэй гэрээний дүн
2009	ХХААХҮЯ	12	17,400,000,000.00	13,277,267,470.00	6	9,581,937,200.00
2010	ХХААХҮЯ	10	9,519,900,000.00	8,813,893,285.50	5	7,030,293,254.00
2011	ХХААХҮЯ	12	12,266,000,000.00	10,513,304,864.00	4	3,974,087,919.00
2012	ХХААХҮЯ	10	12,560,000,000.00	6,971,222,347.00	5	5,369,281,540.00
2013	ХХААХҮЯ	4	2,944,000,000.00	2,713,247,400.00	3	1,785,148,600.00
2014	ХХААХҮЯ	1	250,000,000.00	241,304,415.00		-
2015	ХХААХҮЯ	2	750,000,000.00	479,165,610.00	1	237,861,195.00
2016	ХХААХҮЯ	1	8,901,348,712.00	8,901,348,712.00	1	8,901,348,712.00
2017	ХХААХҮЯ	5	6,040,000,000.00	4,821,452,412.00	3	3,094,736,412.00
2018	ХХААХҮЯ	3	1,336,000,000.00	1,294,873,300.00	2	371,604,500.00
НИЙТ		60	71,967,248,712.00	58,027,079,815.50	30	40,346,299,332.00

Шалгалтаар илэрсэн зөрчлүүдээс дурьдвал:

- 2010 онд Сангийн яамнаас “Үр тариа хураах комбайн худалдан авах” тендер шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтийг хянан үзээд 2010.03.22-ны өдрийн 5/1244 тоот албан бичигт захиалагчийн гэрээ байгуулах шийдвэр хууль, журамд нийцэхгүй байгааг дурдаад, дахин үнэлгээ хийхийг мэдэгдсэн байтал зөрчлийг арилгалгүй "хүчин чадлын хувьд тохиромж муутай, ашиглалтын зардал өндөр" гэсэн тендерийн баримт бичиг тусгаагүй шалтгаанаар хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерээс татгалзаж, уг тендерээс 397 сая төгрөгөөр илүү үнэ санал болгосон "Гацуурт" ХХК-тай гэрээ байгуулсан нь хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4-т заасныг зөрчсөн байна.

- 2011 онд “Үр тариа хураах комбайн худалдан авах” тендерийн үнэлгээний дүгнэлтийг Сангийн яамнаас хянан үзээд 2011 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 5/1409 тоот албан бичгээр “Баяндулаан-Уул” ХХК-ийн ирүүлсэн татварын тодорхойлолтоор өртэй байгаа нь шаардлага хангахгүй гэж мэдэгдсэн байхад хууль зөрчиж гэрээ байгуулсан.
- 2016 онд Сангийн яамнаас “Нийлмэл бордоо нийлүүлэх” тендер шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтийг хянан үзээд тендер шалгаруулалтыг ямар журмаар зохион байгуулсан нь тодорхойгүй, үндэслэл байхгүй, тендер шалгаруулалтыг 17 хоногийн хугацаатай зарласан нь хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасныг, багц тус бүрээр үнэлгээ хийгээгүй нь хуулийн 8.7.3-т заасныг тус тус зөрчсөн, мөн тендерийн баримт бичигт зарим шалгуур үзүүлэлтийг хэт өндөр заасан, түншлэлээр тендерт оролцохыг хориглосон, ямар төрлийн тусгай зөвшөөрөл шаардсан тодорхойгүй нь өрсөлдөөнийг хязгаарлаж улмаар шаардлагад нийцсэн тендер ирүүлэх боломжийг хаасан байх тул тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулахыг 2016 оны 6/244 тоот албан бичгээр мэдэгдсэн байна. Захиалагч дээрх зөрчлийг арилгалгүй, хууль зөрчиж нийт 4 багцад нийт 8,9 тэрбум төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.
- 2009 онд зохион байгуулсан “Нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх” тендерт шалгарсан “Мөнх ногоон тал” ХХК-ийн ирүүлсэн тендер нь захиалагчийн тендерийн баримт бичигт заасан ижил төстэй ажлын туршлагыг нотлох баримт ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан.
- “Жимс, жимсгэний суулгац авах” тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд “Глобал бридж” ХХК-ийн техникийн тодорхойлолтод санал болгосон суулгацын нас шаардлага хангахгүй гэж дүгнэсэн хэрнээ гэрээ байгуулсан.
- “Үр тариа хадгалах элеватор худалдан авах” тендерт “Гурил тэжээл Булган” ХК-ийн эзэмшлийн элеваторыг нийлүүлэхээр “Бэрэн групп” ХХК оролцохдоо тендерийн баримт бичгээ “Гурил тэжээл Булган” ХК-ийн материалаар бүрдүүлсэн байхад шалгаруусан.
- “Хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машин худалдан авах” тендерт шалгарсан “Агромаш” ХХК нь захиалагчийн тендерийн баримт бичигт заасан туршлагын талаарх мэдээлэл ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан.
- “Нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх” тендерт захиалагчийн тендерийн баримт бичгийн ижил төстэй ажлын шаардлага хангахгүй “Нью телеком” ХХК-ийг шалгаруулсан.
- 2011 онд зохион байгуулсан “Төмс хүнсний ногооны өрхийн аж ахуйн багаж хэрэгсэл худалдан авах” тендерт захиалагчийн тендерийн баримт бичигт заасан борлуулалтын орлогын хэмжээнд хүрэхгүй “Ирээдүй энерги” ХХК-ийг шалгаруулсан.
- “ХАА-н чиргүүл, дүүжин машин худалдан авах” тендерт шалгарсан “Онлайн датен систем” ХХК нь захиалагчийн тендерийн баримт бичгийн Олон Улсын ISO стандартын гэрчилгээ, Мэргэжлийн байгууллагын тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангахгүй байхад гэрээ байгуулсан.
- 2017 онд зохион байгуулсан “Дунд оврын трактор, хүнсний ногооны иж бүрдэл техник нийлүүлэх” тендерт шалгарсан “Дорнод газар” ХХК-ийн санал нь

захиалагчийн тендерийн баримт бичигт заасан ижил төстэй ажлын шаардлага хангахгүй, мөн тус тендерийн Багц 4-т шалгарсан “Анхны анжис” ХХК-ийн борлуулалтын орлогын хэмжээ хүрэхгүй, ижил төстэй ажлын туршлагын шаардлага хангахгүй байхад тус тус шалгаруулсан нь хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасныг зөрчсөн байна.

Дээр дурьдсан зөрчлүүдийг зөвхөн ХХААХҮЯ-аас ирүүлсэн архивын баримт материал дээр үндэслэн илрүүлсэн бөгөөд, тендерт оролцсон бусад ААН-үүдийн баримт материалыг ирүүлэхийг хүссэн боловч, ирүүлэхгүй байгаа нь тендер үнэн зөв, хуулийн дагуу хийгдсэн эсэхийг хянаж, дүгнэлт гаргах боломжгүй байдлыг бий болгосон болно.

Түүнчлэн ХХААХҮЯ-наас 2017, 2018 онуудад ОХУ-аас ДиБиЭм Лизинг ХХК-аар дамжуулан худалдан авсан худалдан авсан 8.6 сая ам долларын тоног төхөөрөмж, 3.6 сая еврогийн төхөөрөмжийг шууд худалдан авалт хийж авсан байна. Тоног төхөөрөмжийг шууд худалдан авах тухай шийдвэр, тайлбар, гэрээний төслийг ХХААХҮЯ болон ТЭДСангаас шалгалтын ажлын хэсэгт ирүүлэх хүсэлтийг тавьсан боловч, материалыг ирүүлээгүй болно.

II. Тариаланг дэмжих сангаас зохион байгуулсан худалдан авалтын талаар:

Тус сан нь 2012 оноос эхлэн үрийн буудай, ургамал хамгааллын бодис, бордоо, шатахууны худалдан авах үйл ажиллагааг хэрэгжүүлж ирсэн байна. Сангаас 2012-2018 оны хооронд нийт 55 удаагийн тендерийг зохион байгуулж нийт 60.6 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээг оролцогч ААН-үүдтэй байгуулснаас 10 тендер нь худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж хийгдсэн нь шалгалтаар тогтоогдсон.

Он	Байгууллага	Тендер тоо	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Зөрчилтэй тендерийн тоо	Зөрчилтэй гэрээний дүн
2012	ТЭДС	2	3,100,000,000.00	3,078,820,936.00	1	2,979,772,000.00
2013	ТЭДС	3	2,340,300,000.00	2,245,777,018.00	1	2,051,000,000.00
2014	ТЭДС	10	4,550,963,007.00	4,440,222,588.00	-	-
2015	ТЭДС	10	4,709,650,898.00	4,629,061,252.00	-	-
2016	ТЭДС	13	5,322,103,324.00	5,219,147,088.00	5	180,356,720.00
2017	ТЭДС	8	22,460,000,000.00	17,794,774,123.56	1	77,680,000.00
2018	ТЭДС	9	23,783,902,890.00	23,265,661,323.00	2	1,228,800,000.00
НИЙТ		55	66,266,920,119.00	60,673,464,328.56	10	6,517,608,720.00

Шалгалтаар илэрсэн зөрчлүүдээс дурьдвал:

- Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 2012-2014, 2018 онуудад “Үр ариутгалын болон ургамал хамгааллын бодис нийлүүлэх”, “Бордоо нийлүүлэх”, “Шатахуун нийлүүлэх” сонгон шалгаруулалтуудыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.” гэж заасныг зөрчсөн байна. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж

мөрдөнө." гэж заасан бөгөөд дамжуулан зээлдүүлэх зээлийн үйл ажиллагаа нь энэ хуульд хамаарахгүй байна.

- Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь 2018 оноос худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд нэвтрэх эрх авч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд мэдээлж ажиллаж эхэлсэн байх бөгөөд 2009-2017 онуудад зохион байгуулсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний талаар олон нийтэд зарлан мэдээлээгүй нь хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.5-т дах хэсэгт заасныг тус тус зөрчсөн, мөн дээрх онуудад худалдан авах ажиллагааны цахим системд тендерийн урилга, үр дүнгийн талаар мэдээлээгүй нь хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Нийтлэг зөрчлүүдээс дурьдвал:

Захиалагч тендерийн баримт бичигт ирүүлсэн Үндэсний татварын албаны тодорхойлолтуудаар татварын өртэй дараах ААН-үүдтэй хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.2-т заасныг зөрчиж гэрээ байгуулсан байна. Үүнд:

Огноо	Төсөл арга хэмжээ	Шалгарсан
2009	Үр тарианы комбайн худалдан авах	“Гацуурт” ХХК
2009	Жимс жимсгэний суулгац худалдан авах	“Живэртийн оргил” ХХК
2009	Дугуйт трактор худалдан авах	“Монзол” ХХК
2009	Таримал ургамлын үр ариутгах фунгицид	“Агротрейд импекс” ХХК
2010	Үтрэмийн зарим техник худалдан авах	“Эрдэнэт прогресс” ХХК
2010	Үр тариа цэвэрлэх машин худалдан авах	“Эрдэнэт прогресс” ХХК
2010	Бага оврын бороожуулагч-1 га худалдан авах	“Агротрейд импекс” ХХК
2010	Ногоон хувьсгал хөтөлбөрийн арга хэмжээнд шаардагдах хор цацагч шүршигч худалдан авах	“Агротрейд импекс” ХХК
2011	Төмс хүнсний ногооны өрхийн аж ахуйн багаж	“Агротрейд импекс” ХХК
2013	Чацарганы суулгац нийлүүлэх	“Хархорин” ХК
2018	Жимс жимсгэний суулгац худалдан авах	“Поливит” ХХК,
2018	Нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх	“Мөнх ногоон тал” ХХК

III. Дархан-Уул аймагт Үр тариа хадгалах элеваторын худалдан авалттай холбоотой маргааны талаар:

Үр тариа хадгалах зориулалттай 36.0 мянган тонн багтаамжтай төмөр, бетон хийцийн элеватор шинээр барих төсвийг үндэслэн Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын 21.1.8-д 2014 онд олгох 8.0 тэрбум төгрөг, 2015 онд санхүүжүүлэх 8.0 тэрбум төгрөгийн төсөв батлагджээ.

Тендер шалгаруулалтад “Эм Би инженеринг” ХХК, “Хийц констракшн” ХХК, “Дархан гурил тэжээл” ХК-иуд тендерийн материал авч, Тендер нээхэд нэг оролцогч буюу “Дархан гурил тэжээл” ХК тендер ирүүлсэнээр шалгарсан байна.

Гэвч тендерт 2013 оны санхүүгийн тайлангаар 2.1 тэрбум төгрөгийн богино хугацаат өр, 3.1 тэрбум төгрөгийн урт хугацаат зээл, нийт 5.2 тэрбум төгрөгийн өр, төлбөртэй компанийг шалгаруулжээ.

“ Дархан гурил тэжээл” ХХК-ийн нийлүүлсэн элеватор нь зориулалтын дагуу ашиглах наад захын шаардлагыг хангахгүйгээс буудай авч хадгалах үйл ажиллагаа явагдахгүй байна. Энэ хүлээн авсан элеватор нь тендерийг шалгаруулахаас өмнө Тариаланг дэмжих сан буудай хадгалуулж байгаад хуучин, буудай шатсанаас хөө тортог үүсч, нян бактери үржсэн, эрүүл ахуй ариун цэврийн наад захын шаардлагыг хангахгүй болсон зэргээс шалтгаалан Мэргэжлийн хяналтын байгууллагаас удаа дараалан “Албан шаардлага” өгч, хорио цээрийн дүгнэлт гаргаж байсан боловч, биелэлт нь хангагдаагүй, эвдэрхий бүрэн бус элеваторыг хүлээлгэн өгсөн, хүлээн авсантай холбоотой байна.

ТЭДСангийн зүгээс Эрүүгийн цагдаагийн газарт уг асуудлаар хандсаны дагуу шалгалтыг явуулж байгаад албан тушаалын гэмт хэргийн холбогдолтой байж болзошгүй гэж үзсэн тул Авлигатай тэмцэх газарт шилжүүлжээ.

Авлигатай тэмцэх газар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа бөгөөд одоогийн байдлаар хөрөнгийн үнэлгээг мэргэжлийн үнэлгээчдээр хийлгэж, 11,240,745,297 төгрөгөөр тогтоолгон, Тариаланг дэмжих сангаас хохирогчийн төлөөлөн нэхэмжлэгч томилуулан ажиллуулж байна.

IV. Үрийн буудайн худалдан авалт:

Тариаланг дэмжих сангаас үрийн буудайн нөөц бүрдүүлэх зорилгоор дотоодын зах зээлээс болон импортын үрийн буудайг худалдан авдаг байна. Үрийн буудайг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдлөг болгон ажилладаггүй бөгөөд зөвхөн үрийн буудай зарах хүсэлт гаргасан аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг үндэслэн ХХААХҮ-ийн сайдын баталсан үрийн буудай худалдан авах үнэ болон нийт хэмжээнд тулгуурлан худалдан авалтыг зохион байгуулан ажилладаг байна.

ХХААХҮЯ-ны тусгай зөвшөөрөлтэй үр үйлдвэрлэх, үржүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг 11 дотоодын ААН-үүдээс гадна үрийн буудай импортлон оруулж ирсэн ААН-үүдээс МХЕГ-ын шинжилгээний дүгнэлтэд үндэслэн худалдан авсан байна.

Сангийн худалдан авсан үрийн буудайн хураангуй мэдээ:

Он	ААН-ын тоо	Хэмжээ /тонн/	Нэгжийн үнэ /төг/	Нийт Үнэ
2006	12	8,049.0	290000; 230000	2,199,969,000
2007	-	-	-	-
2008	19	6,372.0	630,000	4,014,560,000
2009	15	3,221.0	800000; 530000	2,093,530,000
2010	8	1,580.0	550,000	868,725,000
2011	8	2,889.0	550,000	1,588,950,000
2012	5	1,612.0	550,000	1,190,750,000
2013	2	504.0	550,000	277,200,000
2014	17	8,482.0	750000; 830000	5,900,343,000
2015	17	4,734.0	780,000	3,692,520,000
2016	20	10,244.0	780,000	8,241,847,000
2017	40	23,390.0	780,000	17,570,999,000
2018	14	12,022.0	870000; 750000	8,902,739,400
НИЙТ		83,099.0		56,542,132,400

Тус сан нь жил бүр худалдан авах буудайн хэмжээг тооцож, тогтоодоггүй бөгөөд зөвхөн хүсэлт гаргасан ААН-үүдээс худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн байна.

Тус сангаас 2006-2018 оны хооронд нийт 83.1 мянган тонн 56.5 тэрбум төгрөгийн үрийн буудайг худалдан авсан бөгөөд ХХААХҮ-ийн сайдын тушаалаар худалдан авах буудайн үнэ болон худалдан борлуулах үнийг жил бүр шинэчлэн тогтоодог байна. Харин худалдан авах нийт буудайн хэмжээг яамнаас тогтоож, санд албан бичгээр чиглэл хүргүүлдэг байна.

ХХААХҮ-ийн сайдын тушаалаар тогтоосон үнээс хамааран 2005-2013 оны хооронд үрийн буудай худалдан авах, борлуулах үйл ажиллагаанаас цэвэр дүнгээр ашигтай ажиллаж байсан бол 2014-2018 оны хооронд тогтмол алдагдалтай ажилласан байна. Тухайлбал, 2018 онд санд худалдан авах үрийн буудайн үнийг чанараас нь хамааран тонн тутамд 780-830 мянган төгрөг байхаар тогтоосон бол сангаас худалдан борлуулах үнийг тонн тутмыг 570-620 төгрөг байхаар тогтоосон байна. Энэ нь сан буудайн борлуулалтаас 2018 онд тонн тутамд 210 мянган төгрөгийн алдагдал буюу нийт 252.0 орчим сая төгрөгийн цэвэр алдагдал хүлээх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Үрийн буудайн үнэ тогтоосон ХХААХҮ-ын сайдын тушаалын хураангуй:

Он	Буудайн төрөл	Тушаалын №	Буудай авах үнэ /мян.төг/	Буудай зарах үнэ /мян.төг/	Ашиг, алдагдал
2005		№91	200	200	
2006	Дотоод	№49	230	230	Ашигтай
	Импорт			290	
2007	Дотоод	№65	235	235	
2008	Дотоод	№30	630		
2009	Дотоод	№208	530		
	Импорт	№110		800	
2010	Дотоод	№209	550	560	Ашигтай
	Импорт	№95	620	680	Ашигтай
2011	Дотоод	№155	550	650	Ашигтай
	Импорт	№155		680	
2012	Дотоод	№16	550	650	Ашигтай
	Импорт	№64		680	
2013	Дотоод	№126	550	600	Ашигтай
	Импорт	№40		765	
2014	Элит	№107	830	830	Алдагдалтай
	Дотоод	№107	750	680	
	Импорт	№34	900	880	
2015	Дотоод	№119	780	800	Ашигтай
	Импорт	№49		900	
2016	Репродукци,	№22; №55	830	800-835	Алдагдалтай
2017	Элит,	№122	750-830	800,000.0	
2018	Импорт	№52; №152	780-830	570-620	

V. Хүнсний буудайн худалдан авалт:

Тус сан нь 2011-2017 хооронд нийт 1268 ААН-ээс 449.1 мянган тонн буудайг худалдан авахад нийт 161.2 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Хүнсний буудайн худалдан авалтын мэдээ:

Он	ААН-ын тоо	Хэмжээ /тонн/	Нэгжийн үнэ /төг/	Нийт Үнэ
2011	649	192,134.2	350,000	67,263,885,472
2012	309	50,011.0	280,000	14,003,071,880
2013	248	26,135.3	320,000	8,363,309,632
2014	364	30,531.3	550,000	16,792,189,755
2015	193	6,464.6	550000, 570000	3,646,153,790
2016	634	68,919.8	560,000	37,467,185,348
2017	353	23,794.6	600000; 560000; 530000	13,722,323,247
2018	374	51,121.0		
НИЙТ		449,111.7		161,258,119,124

Тухайн жилд сангаас худалдан борлуулах, санд худалдан авах хүнсний болон үрийн буудайн үнийг ХХААХҮ-ийн сайдын тушаалаар дараах байдлаар тогтоож ирсэн байна.

Он	Буудайн төрөл	Тушаалын №	Буудай авах үнэ /мян.төг/		Буудай зарах үнэ /мян.төг/				Ашиг, алдагдал
			Өр авлагад	Худалдан авалт					
2008	Дотоод	№165		430.00	400.00	330.00	270.00	220.00	Алдагдалтай
2009	Дотоод	№208		330.00	270.00	220.00	310.00	150.00	Алдагдалтай
2010	Дотоод	А/209		350.00	350.00	380.00	350.00	280.00	Алдагдалтай
2011	Дотоод	А/155		350.00	350.00	280.00			Алдагдалтай
2012	Дотоод	А/16		280.00	280.00				
2013	Дотоод	А/126		320.00	460.00				Ашигтай
2014	Дотоод	А/107		550.00	Тушаал олдоогүй				
2015	I зэрэг	А/142		570.00	575.00				Ашигтай
	II зэрэг			560.00	565.00				
	III зэрэг			550.00	555.00				
2016	I зэрэг	А/15		560.00	560.00				Алдагдалтай
	II зэрэг			540.00	520.00				
	III зэрэг			520.00					
	IV зэрэг	А-22		500.00	480.00				
2017	I зэрэг	А122	600.00	560.00	580.00				Ашигтай
	II зэрэг		560.00	530.00	560.00				
	III зэрэг		520.00	500.00	540.00				
2018	I зэрэг	А/164	600.00	560.00	580.00				Ашигтай
	II зэрэг		580.00	540.00	580.00				
	III зэрэг		560.00	520.00	560.00				
	IV зэрэг		540.00	500.00	560.00				

Дээрх тушаалаас харахад ихэнх жилд сангийн өрөнд суутган авах болон худалдан борлуулах буудайн үнийг санд буудай худалдан авах үнээс тонн тутамд 10-50 мянган төгрөгөөр багаар тогтоосон байна. Үүнээс үүдэн сан нь жил тутам буудайн борлуулалтаас алдагдал хүлээж ирсэн бөгөөд сангийн өглөг, авлага жил тутам өсөхөд гол нөлөөг үзүүлсэн байна. Тус сан нь хүнсний буудайн хөдөлгөөнийг худалдан авсан үнээр баталгаажуулан бүртгэдэггүйгээс үүдэн буудайн борлуулалтаас жил болгон хэдэн төгрөгийн алдагдал хүлээснийг тооцож гаргах боломжгүй нөхцөл байдлыг бий болгосон байна.

Хүнсний буудай нийлүүлсэн ААН-ийн өрийн суутгалын мэдээ:

Он	Нийт худалдан авалт	Өрийн суутгал	Цэвэр худалдан авалт
2011	67,246,979,100.00	22,332,782,071.40	44,909,332,028.60
2012	14,003,071,880.00	2,683,204,319.00	11,319,867,561.00
2013	8,363,309,632.00	5,770,286,575.53	2,593,023,056.47
2014	16,792,189,755.00	12,608,671,672.48	4,183,518,082.52
2015	3,646,153,790.00	3,288,076,617.96	358,077,172.04
2016	37,467,185,348.00	22,671,994,326.21	14,795,191,021.79
2017	27,444,646,493.36	6,427,736,976.00	21,016,909,517.36
2018			-
Нийт	174,963,535,998.36	75,782,752,558.58	99,175,918,439.78

4. Сангаас олгодог дэмжлэгүүдийн талаар:

Тариаланг дэмжих сангаас дараах төрлийн дэмжлэгүүдийг тариаланчдад олгож ажилладаг байна. Үүнд:

- Үрийн буудай;
- Шатахуун;
- Жимс, жимсгэний аж ахуй;
- Бордоо;
- Хүлэмж;
- Тариалангийн техник, тоног төхөөрөмж.

Дээрх дурьдсан дэмжлэгүүдээс үрийн буудай, шатахуун, бордооны дэмжлэгийг тухайн жилдээ багтааж төлөх нөхцөлтэйгөөр, техник тоног төхөөрөмж, хүлэмж, жимсний аж ахуйн дэмжлэгийг 4-5 жилийн хугацаатай хүүгүй зээл хэлбэрээр олгож ирсэн байна.

- Үрийн буудайн дэмжлэг:

Үрийн буудайн дэмжлэг авсан ААН-ийн өрийн сүүтгалын мэдээ:

Он	Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн зээл
2005	67	414,514,000.00	-	-
2006	140	2,059,231,000.00	154,251,300.00	154,251,300.00
2007	69	773,873,500.00	59,631,000.00	59,631,000.00
2008	296	4,955,757,600.00	212,928,562.00	212,928,562.00
2009	464	9,680,070,600.00	2,051,147,476.00	2,051,147,476.00
2010	204	4,379,226,200.00	319,974,080.00	319,974,080.00
2011	269	5,664,754,300.00	608,024,128.50	608,024,128.50
2012	131	2,150,577,350.00	-	-
2013	99	2,183,398,200.00	381,653,572.20	381,653,572.20
2014	280	12,017,220,669.62	438,399,982.80	438,399,982.80
2015	189	3,018,752,000.00	470,105,337.00	470,105,337.00
2016	339	11,379,391,793.00	3,335,692,985.00	3,335,692,985.00
2017	213	9,946,884,650.00	3,318,249,135.66	3,318,249,135.66
2018	568	18,488,912,421.60	14,837,036,167.40	-
НИЙТ	3328	87,112,564,284.22	26,187,093,726.56	11,350,057,559.16

Тус сангаас 2005-2018 оны хооронд давхардсан тоогоор нийт 3328 ААН-д 87.1 тэрбум төгрөгийн үрийн буудайн дэмжлэг олгосон бөгөөд нийт зээлийн үлдэгдэл 26.2 тэрбум төгрөг, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 11.3 тэрбум төгрөг байна.

ААН-үүдэд үрийн буудайн дэмжлэг олгох, эргэн төлүүлэх, хяналт тавих журам байхгүй бөгөөд зээлийн барьцаа хөрөнгийг бүртгэх үйл ажиллагаа хангалтгүй тул шинээр олгож буй зээлүүд чанар муудсан тохиолдолд эргэн төлөлтийн үүргийг хангуулах барьцаа хөрөнгийн баримт бүрдүүлбэр хангалтгүй байна.

- Шатахуун:

Тариаланг дэмжих сангаас нефтийн бүтээгдэхүүн импортлогч ААН-үүдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр шатахуун худалдан авч, түүнийгээ тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, ААН-үүдэд дамжуулан зээлдүүлэх үйл ажиллагааг эрхэлдэг. Өөрөөр хэлбэл тариаланч, нефт импортлогч 2-ын дундын батлан даагч байдлаар гэрээнд оролцож, эргэн төлөлтийн бүхий л эрсдэлийг өөртөө хүлээдэг байна. Тус сан нь 2007-2018 оны хооронд давхардсан тоогоор 8,747 ААН-д нийт

54.9 тэрбум төгрөгийн шатахууны дэмжлэг олгосноос 17.0 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй үүнээс 11.1 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн зээл байна.

Шатахууны дэмжлэгийн хураангуй мэдээ:

Он	Зээлдэгчийн тоо	Нийт олгосон зээл	Зээлийн үлдэгдэл /2018.09.30/	Хугацаа хэтэрсэн зээл
2007	59	418,912,600.00	-	-
2008	48	540,473,000.00	23,380,000.00	23,380,000.00
2009	1032	11,295,407,259.00	2,491,549,191.27	2,491,549,191.27
2010	943	7,475,739,634.00	1,390,331,437.88	1,390,331,437.88
2011	1207	7,451,311,190.20	2,268,580,096.88	2,268,580,096.88
2012	590	1,749,503,905.00	-	-
2013	821	3,061,660,100.00	223,211,231.73	223,211,231.73
2014	754	4,638,330,437.00	333,047,998.00	333,047,998.00
2015	776	3,422,171,911.00	717,320,448.20	717,320,448.20
2016	945	3,245,408,625.00	881,842,707.00	881,842,707.00
2017	833	5,347,922,400.00	2,799,323,379.79	2,799,323,379.79
2018	739	6,236,336,305.60	5,870,769,260.00	-
НИЙТ	8747	54,883,177,366.80	16,999,355,750.75	11,128,586,490.75

Тариалангын үйл ажиллагааны циклтэй холбоотойгоор 4 дүгээр сард тариалалтад, 6 дугаар сард уринш бэлтгэхэд, 8 дугаар сард хураалтад зориулж нефт импортлогч ААН-үүдтэй тухайн үеийн зах зээл дээрх жижиглэнгийн болон бөөний үнээр гэрээг байгуулдаг байна. Шатахууны дэмжлэгийг олгоходоо хүсэлт гаргасан ААН-үүдтэй гэрээ байгуулж, гэрээний үнийн дүнгээр зөвшөөрлийн хуудас олгодог бөгөөд хугацааны эцэст ААН, нефт импортлогч 2-оос ирүүлсэн тооцооны хуудсаар гүйцэтгэлийг баталгаажуулсны дараа санхүүжилтийг олгодог байна.

○ **Жимс, жимсгэний аж ахуй хүлэмж, суулгац;**

Тариаланг дэмжих сан нь үндсэн дэмжлэгээс гадна салбарын сайдын багцад батлагдсан жимс, жимсгэний үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд худалдан авч тухайн санд шилжүүлсэн хүлэмж, суулгац, жимс жимсгэнэ хадгалах хөргөлттэй агуулахыг иргэд, аж ахуйн нэгжид зээлийн гэрээгээр худалдаж байна. Зарим онд жимс, жимсгэний аж ахуй эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд хөнгөлөлттэй нөхцөлтэй мөнгөн зээлийг олгосон байна.

Он	Зээлдэгчийн тоо	Олгосон зээлийн хэмжээ	Зээлийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн
2009	78	920,000,000.00	291,837,769.00	291,837,769.00
2010	111	484,388,500.00	363,608,800.00	363,608,800.00
2011	589	1,772,580,000.00	1,671,273,885.00	1,671,273,885.00
2012	483	1,739,649,210.00	1,611,041,173.00	1,611,041,173.00
2013	324	4,000,369,815.00	3,392,174,029.00	1,174,099,782.00
2014	118	1,536,276,028.00	1,533,770,608.00	287,634,283.00
2015	66	301,725,504.00	241,062,396.00	43,531,049.00
2016	12	139,364,272.00	139,364,272.00	50,841,531.95
2017	103	374,080,866.98	323,620,458.96	69,218,223.95
2018	317	1,436,694,647.44	1,355,480,681.10	88,164,951.98
НИЙТ	2201	12,705,128,843.42	10,923,234,072.06	5,651,251,448.88

○ Бордоо:

Тариаланг дэмжих сангаас 2013-2018 оны хооронд давхардсан тоогоор 792 зээлдэгчид 10.4 тэрбум төгрөгийн бордоог олгосноос нийт үлдэгдэл 2.9 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1.8 тэрбум төгрөг байна.

Бордоо авсан ААН-үүдийн хураангуй мэдээ:

Он	Зээлдэгчийн тоо	Гэрээний дүн	Зээлийн үлдэгдэл /2018.09.30/	Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл
2013	54	425,372,250.00	41,892,900.00	41,892,900.00
2014	17	360,925,000.00	42,627,241.16	40,422,241.16
2015	38	1,933,162,900.00	581,805,134.00	499,425,134.00
2016	361	4,557,216,634.29	754,217,069.50	439,323,569.50
2017	121	2,336,339,446.43	982,442,163.00	797,560,863.00
2018	201	757,741,300.00	532,312,300.00	-
НИЙТ	792	10,370,757,530.71	2,935,296,807.66	1,818,624,707.66

ААН-үүдэд бордооны зээл олгох, эргэн төлүүлэх, хяналт тавих журам байхгүй бөгөөд зээлийн барьцаа хөрөнгийг бүртгэх үйл ажиллагаа хангалтгүй тул шинээр олгож буй зээлүүд чанар муудсан тохиолдолд эргэн төлөлтийн үүргийг хангуулах барьцаа хөрөнгийн баримт бүрдүүлбэр хангалтгүй байна.

○ Ургамал хамгааллын бодис:

Тариаланг дэмжих сангаас 2007-2018 оны хооронд давхардсан тоогоор 4020 зээлдэгчид 34.3 тэрбум төгрөгийн ургамал хамгааллын бодис олгосноос нийт үлдэгдэл 8.9 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 5.1 тэрбум төгрөг байна.

Ургамал хамгааллын бодис авсан ААН-үүдийн хураангуй мэдээлэл:

Он	Зээлдэгчийн тоо	Гэрээний дүн	Зээлийн үлдэгдэл /2018.09.30/	Хугацаа хэтэрсэн зээл
2007	51	221,542,200.00	12,545,000.00	12,545,000.00
2008	61	56,964,980.00	-	-
2009	238	750,380,400.00	37,629,752.00	37,629,752.00
2010	367	873,931,500.00	30,164,300.00	30,164,300.00
2011	366	2,621,623,767.00	588,843,961.55	588,843,961.55
2012	355	3,716,636,330.00	634,185,293.06	634,185,293.06
2013	436	3,248,839,100.00	298,941,249.40	298,941,249.40
2014	450	3,832,509,000.00	308,202,890.00	308,202,890.00
2015	452	4,187,561,657.14	573,170,806.00	573,170,806.00
2016	426	5,288,513,142.86	1,221,191,320.56	1,221,191,320.56
2017	377	3,552,419,821.43	1,382,299,750.95	1,382,299,750.95
2018	441	5,912,733,671.43	3,796,375,988.00	-
Нийт	4020	34,263,655,569.86	8,883,550,311.52	5,087,174,323.52

ААН-үүдэд ургамал хамгааллын бодис зээлээр олгох, эргэн төлүүлэх, хяналт тавих журам байхгүй бөгөөд зээлийн барьцаа хөрөнгийг бүртгэх үйл ажиллагаа хангалтгүй тул шинээр олгож буй зээлүүд чанар муудсан тохиолдолд эргэн төлөлтийн үүргийг хангуулах барьцаа хөрөнгийн баримт бүрдүүлбэр хангалтгүй байна.

○ Тариалангийн техник, тоног төхөөрөмж.

Тариаланг дэмжих сангаас сүүлийн 14 жилд /2005-2018 он/ нийтдээ 161.8 тэрбум төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг худалдан авч, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг, аж ахуйн нэгж, иргэдэд зохих урьдчилгааг төлүүлэн, 2-5 жилд хуваан төлөх нөхцөлтэй гэрээ байгуулан олгож, дэмжлэг үзүүлж ажиллажээ.

Нийт бэлтгэгдсэн техник, тоног төхөөрөмжийг эх үүсвэрээр нь ангилж үзвэл улсын төсвийн хөрөнгөөр 56.9 тэрбум, өөрийн хөрөнгөөр 48.4 сая, зээл тусламжийн эх үүсвэрээр 67.6 тэрбум, бусад эх үүсвэрээр 37.2 тэрбум /ДБМ Лизинг/ төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг худалдан авч нийлүүлжээ.

Тоног төхөөрөмжийн худалдан авалтын хураангуй мэдээлэл:

Он	УТ-ын хөрөнгөөр	Өөрийн хөрөнгөөр	Зээл, тусламж	Бусад	Нийт	Хугацаа хэтэрсэн	
2005	74,950.0	48,448.0	-	-	123,398.0	22,533,806.8	
2006	476,120.0	-	-	-	476,120.0		
2007	939,935.0	-	-	-	939,935.0		
2008	9,788,535.0	-	529,390.0	-	10,317,925.0		
2009	15,575,938.8	-	-	-	15,575,938.8		
2010	7,732,188.6	-	-	-	7,732,188.6		
2011	8,872,091.0	-	-	-	8,872,091.0		
2012	10,309,746.7	-	43,598,520.0	-	53,908,266.7		
2013	3,162,867.1	-	-	-	3,162,867.1		
2014	-	-	-	-	-		
2015	-	-	23,506,695.2	-	23,506,695.2		
2016	-	-	-	-	-		
2017	-	-	-	10 сая ам.дол	-		-
2018	-	-	-	5.2 сая евро	-		-
Нийт	56,932,372.20	48,448.00	67,634,605.20	37,197,432.20	161,812,857.60		22,533,806.80

Бага оврын тракторын талаар:

БНХАУ-ын Засгийн газраас олгосон хөнгөлттэй зээлийн хэлэлцээрээр 40,0 сая долларын хөрөнгөөр Хөдөө аж ахуйн бага оврын болон газар тариалангийн зориулалттай техник, тоног төхөөрөмж худалдан авч хөнгөлттэй нөхцлөөр олгох ажлын хүрээнд 2012 онд 8400-ширхэг Бага оврын трактор нийлүүлэгджээ. 2018 оны 12.30-ны байдлаар бага оврын трактор 4 ширхэг үлдэгдэлтэй байгаа ба нийт 8396 ширхэгийг борлуулсан байна. Уг БОТ-уудыг 2012 оноос эхлэн нийт 6000 гаруй ААН, иргэдэд 43,598,520,000 төгрөгийн гэрээгээр хөнгөлттэй зээлийн нөхцөлөөр олгосон ба үүний 21,698,354,925.54 төгрөгийг урьдчилгаа төлбөр болон зээлийн эргэн төлөлтөөр төвлөрүүлэн 21,900,165,074.54 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Үүнээс 4,286,736,575.92 төгрөг нь хугацаандаа байгаа ба үлдэх 17,613,428,498.54 төгрөг нь хугацаа хэтэрсэн авлага байна.

Энэхүү зээлийн эргэн төлөлт нь цаг хугацаандаа гэрээний дагуу төлөгдөхгүй, ихээхэн хэмжээгээр хуримтлагдсан байгаа талаар трактор авсан ААНБ, иргэдтэй холбогдоход дараах тайлбар болон хүндрэлтэй асуудлууд гарч байна. Үүнд:

- Сонгуулийн сурталчилгаанд ашиглаж, үлдэгдэл төлбөрийг хаасан мэтээр иргэдэд мэдээлэл өгсөн.
- 2015 оны өвөлжилтийн бэлтгэл хангах, гамшийн эрсдлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэдэд тараагдсан гэж ойлгуулсан.
- Бүртгэлтэй, гэрээний хувьд бичигдсэн утасны дугаарууд нь ихэнхдээ холбогдохгүй байдаг,
- Зээлдэгчид дунд Тариалан эрхлэлтийг дэмжих сантай байнгын харилцаатай үр тарианы чиглэлийн ААН, иргэд бараг байхгүй байгаа,
- Анхнаасаа 8400 ширхэг Бага оврын тракторыг барьцаа хөрөнгө байхгүйгээр олгосон зэргээс шалтгаалан эргэн төлөлтийг удаашируулсан байна.

○ Хүнсний буудайн дэмжлэг:

Сангаас хүнсний буудайн дэмжлэг хэлбэрээр иргэд болон гурилын үйлдвэрүүдэд 2007-2018 онуудад нийт 236.9 тэрбум төгрөгийн буудайг хүүгүй зээл хэлбэрээр борлуулсан бөгөөд нийт зээлийн эргэн төлөгдөөгүй үлдэгдэл 22.2 тэрбум төгрөг байгаагаас 20.2 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн байна.

Хүнсний буудайн дэмжлэгийн хураангуй мэдээ:

Он	Зээлдэгчийн тоо	Нийт зээл	Зээлийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн
2007	10	2,752,723,480.00	-	-
2008	4	115,028,160.00	-	-
2009	44	19,325,863,400.00	-	-
2010	11	14,451,917,200.00	-	-
2011	43	41,422,559,640.00	-	-
2012	51	44,737,011,380.00	9,729,733,945.40	9,729,733,945.40
2013	41	33,671,865,977.00	772,564,400.00	772,564,400.00
2014	25	13,019,760,016.60	908,634,196.00	804,434,196.00
2015	18	13,094,099,953.00	485,093,053.00	485,093,053.00
2016	9	4,781,040,530.00	273,564,550.00	273,564,550.00
2017	13	43,596,999,442.00	8,088,645,467.90	8,088,645,467.90
2018	7	5,939,594,956.00	1,923,268,998.00	-
НИЙТ	276	236,908,464,134.60	22,181,504,610.30	20,154,035,612.30

○ Сангаас үзүүлсэн дэмжлэгүүдийн баримт материалын бүрдэл:

- Нийт дэмжлэгүүдийн **харилцааг зохицуулсан журамгүй**. Үүнээс гадна Засгийн газрын 2012 оны 77 дугаар тогтоолоор 2009 оны 350 дугаар тогтоол болон тус тогтоолоор батлагдсан “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгоход баримтлах журам” хүчингүй болгосныг одоо болтол мөрдөж байна. Мөн Гүйцэтгэх захирлын 2015 оны А07 дугаар тушаалаар батлагдсан “Тариалан эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх журам” нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын албан бичгийн хүрээнд

боловсруулагдсан бөгөөд уг журмыг 2015-2016 онд хэрэгжүүлж байгаад 2017 оноос хэрэглээгүй гэх ба хүчингүй болгоогүй.

- Барьцаа хөрөнгийн үнэлгээг үнэлгээ хийх эрх бүхий зөвшөөрөлтэй байгууллагаар хийлгээгүй, хариуцсан мэргэжилтнүүд өөрсдөө үнэлгээг тооцож гэрээ байгуулдаг.
- Хүлэмж болон техник, тоног төхөөрөмжөөс бусад дэмжлэгт барьцаа хөрөнгийн гэрээ байгуулдаггүй байна.
- Барьцаа хөрөнгийн гэрээнд үл хөдлөх хөрөнгийг барьцаалсан талаарх тэмдэглэгээ, бүртгэл хийгдсэнийг УБЕГ-ын байцаагчийн тэмдэг дарснаар албаждаг гэж тайлбарласан боловч “Фамилисон ХХК”, “Харуул алт нөхөрлөл”, ИНТОСЭ ХХК, Жавхлант буудай ХХК, Хайрхан-Оргил уул ХХК-иуд нь тэмдэг даруулаагүй.
- Техник, тоног, төхөөрөмжийн хувьд Гүйцэтгэх захирлын 2017 оны А34 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар “Дамжуулах түрээсийн үйлчилгээ хүсэгчдэд тавигдах шалгуур үзүүлэлт, бүрдүүлэх материалын жагсаалт”-ыг баталсан боловч дараах зөрчил илэрч байна. Үүнд:
 - Гүйцэтгэх захирлын баталсан уг жагсаалтын дагуу баримтыг иж бүрэн авч хэвшээгүй байна. Тухайлбал, Тамэд Эрдэнэ ХХК нийт 14 баримт бүрдүүлэхээс 8-н баримт дутуу, Хайрхан-Оргил уул ХХК 12 баримт дутуу бүрдүүлж, архивлагдсан.
 - Мөн техник, тоног төхөөрөмж олгох зөвшөөрлийн хуудасгүй зээл олгосон. /Тамэд-Эрдэнэ ХХК, Жавхлант буудай ХХК, Хайрхан-Оргил уул ХХК/, техник, тоног төхөөрөмж хүлээлцэх актанд ТЭДС, ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК гарын үсэх зурдаггүй зэргээс үзэхэд дотоод хяналт хангалтгүй гэж үзэхээр байна.
 - Урьдчилгаа төлбөрийн баримтыг Жавхлант буудай ХХК, Хайрхан-Оргил уул ХХК-иуд хавсаргаагүй байгаагаас үзэхэд урьдчилгаа төлбөр төлөөгүй байхад зээл олгосон гэж үзэхээр байна.
 - Түүнчлэн **Жавхлант буудай ХХК** нь гэрээний 2.3-т зааснаар үнэлгээний 70%-ийн барьцаанд 19-н газар тавьснаар барьцааны гэрээ байгуулсан байх бөгөөд газар эзэмших эрхийн гэрчилгээ нь Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын Засаг даргын **2008 оны 6-р сарын 24-ний өдрийн 83 тоот шийдвэрийг үндэслэж, 2006 оны 6-р сарын 26-ны өдөр олгохдоо 60 жилийн хугацаагаар олгосон** байгаа нь зөрчилтэй эрхийн бичиг гэж үзэхээр байна. Дээрх 19 газрын гэрчилгээнээс 18-ыг хавсаргасан ба газар эзэмших эрхийн гэрчилгээ **0204774 дугаартай газрыг давхардуулан барьцаалсан** байна. ТЭДС-гийн барьцаанд байгаа тэмдэглэгээ нь зөвхөн 0204780 /2015 онд/, 0204774 /2016 онд/ дугаартай гэрчилгээнд хийгдсэн байна.

- Үүнээс гадна зээл олгоход шаардагдах ААН, иргэдийн банк, санхүүгийн байгууллагад зээлтэй эсэх, үл хөдлөх хөрөнгө барьцаанд байгаа эсэх талаарх үл хөдлөх хөрөнгийн лавлагаа, тодорхойлолтыг авдаггүй.
- Тус сангаас олгож буй бүх дэмжлэгийн зээлийг давхардуулан авч, өр үүсгэх эрсдэлтэйгээс гадна барьцаанд 1 хөрөнгө тавьсан тохиолдол гарч байна. Тухайлбал, Дорнод шим ХХК нь шатахууны дэмжлэгээс 88.8 сая төгрөг, УХБ, бордооны дэмжлэгээс 289.9 сая төгрөг, нийт 378.7 сая төгрөгийн зээл авахдаа зээлийн барьцаанд 1 газар эзэмших эрхийн гэрчилгээг /№000298673/ дээрх зээлүүдэд тавьсан байна.
- Үүнээс гадна Ургац хүдэр ХХК нь шатахууны дэмжлэгээс 262.4 сая төгрөг, УХБ, бордооны дэмжлэгээс 102.6 сая төгрөг, нийт 365.0 сая төгрөгийн зээл авсан бөгөөд үрийн буудай, ургамал хамгааллын бодисын 2 өөр зээлд газар эзэмших эрхийн 0121818, 0121850 дугаартай гэрчилгээг давхардуулан барьцаанд тавьсан.
- Мөн хүсэлт болон аймгийн ХААГ-ын тодорхойлолт хавсаргаагүй байгааг тодруулахад хариуцсан мэргэжилтэн "яамнаас ирүүлсэн уриншийн мэдээнд тус компанийн нэр орсон тул авдаггүй" гэсэн тайлбарыг өгөв. Гэтэл тус яамнаас ирүүлсэн уриншийн мэдээ нь албажаагүй, excel файлаар ирсэн байх тул уг жагсаалт өөрчлөгдөх эрсдэлтэйгээс гадна хангамжийн мэргэжилтнүүд тэр бүр жагсаалтын дагуу олгодоггүй байна.

Дээрх байдлаас үзэхэд ТЭДС-ийн хэмжээнд дотоод хяналтын механизм огт хэрэгждэггүй, эрсдэлийн үнэлгээ хийдэггүй, хууль эрхзүйн орчны хяналт дулимаг байгаа нь илт байх тул цаашид тус сангийн гол үйл ажиллагаа болох дэмжлэг, урамшууллын харилцааг зохицуулсан журмуудыг яаралтай баталж, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчлүүдийг арилгах, эмхлэн цэгцлэх, сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг тооцож, хамгаалах арга хэмжээг авч ажиллах нь зүйтэй байна.

/Жич: Дэмжлэг авсан аж ахуйн нэгжүүдийн баримт бичгийн бүрдүүлбэрт хийсэн түүвэр судалгааны баримтыг хавсаргав./

5. Сангаас олгосон урамшууллын талаар:

Тариалангын тухай хуулийн (19.1 дэх заалт) дагуу тус сан нь 2007 оноос эхлэн буудай үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдийн дотоодын гурилын үйлдвэр, Тариаланг дэмжих сан болон Онцгой байдлын ерөнхий газарт тушаасан буудайн тонн тутамд урамшуулал тооцон олгож эхэлсэн байна. Ингэхдээ жил бүр Засгийн газрын тогтоолоор тушаасан буудайн урамшууллын тонн тутамд олгох мөнгөн хэмжээг тогтоож, үүнийг үндэслэн ХХААХҮ-ийн сайдын тушаалаар урамшуулалд хамрагдах ААН, иргэдийн жагсаалт, урамшууллын хэмжээг баталж, олгосон байна.

Урамшуулал олгох тухай тушаал шийдвэрийн жагсаалт:

Он	ЗГ-н тогтоол №	Огноо	Урамшуулал /1 тонн/	Сайдын тушаалын №	Дүн
2007	227	2007.09.19	60,000	130	3,953,227,800
2008	47	2008.12.03	80,000	50, 65	11,164,031,960
2009	350	2009.11.25	50,000	279, 261	10,499,731,400
2010				A/ 273	10,906,406,150
2011				A/ 227, A/ 258	14,556,477,100
2012	77	2012.10.06	100,000	A / 39	27,829,458,000
2013	366	2013.11.09	150,000		25,306,934,280
2014	31	2015.01.26	70,000	A/11	24,727,055,500
2015	202	2016.04.11	50,000	A/57	5,591,482,200
2016	62	2017.02.22	50000-55000	A/26	14,962,349,400
2017	48	2018.02.06	50000-60000	A/50	7,873,213,100
2018		2019.01.23	45,000		12,900,000
НИЙТ					157,383,266,890

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 350 дугаар тогтоолыг үндэслэн ХХААХҮ сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 24/34 тоот тушаалаар “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгоход баримтлах журам”-ыг баталсан байна. Гэвч, тус журмыг гаргахдаа үндэслэсэн 2009 оны 350 дугаар тогтоолыг 2012 оны 77 дугаар ЗГ-ын тогтоолоор хүчингүй болгосон байх бөгөөд үүнтэй холбоотойгоор тус журмыг шинэчлэн батлагүй бөгөөд, 2012 онд хүчингүй болсон журмыг баримтлан тариаланчдад урамшуулал олгох үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна.

Буудайн урамшуулал олгосон талаарх мэдээ:

Он	Хамрандсан тоо	Буудай /тонн/	Урамшуулал /төг/
2007	217	65,887.13	3,953,227,800.00
2008	393	139,549.97	11,164,032,000.00
2009	700	209,994.63	10,499,731,350.00
2010	796	218,128.12	10,906,406,050.00
2011	906	291,129.54	14,556,477,100.00
2012	797	278,294.58	27,829,458,000.00
2013	806	248,878.84	25,306,934,280.00
2014	908	349,881.20	24,727,055,500.00
2015	610	111,829.64	5,591,482,200.00
2016	726	292,449.30	14,962,349,400.00
2017	597	128,039.03	7,873,213,100.00
Нийт	7456	2,334,061.99	157,370,366,780.00

/Урамшуулал авсан иргэн, ААН-ийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас харна уу./

Урамшуулал авсан ААН, иргэдийн мэдээллээс харахад улаанбуудай тарьсан ААН-үүд нь өөрсдийн гурилын үйлдвэрт /харилцан хамааралтай ААН-үүдийг оруулагүй/ 2013-2017 оны хооронд 38.1 мянган тонн улаанбуудай нийлүүлж 2.7

тэрбум төгрөгийн урамшууллыг авсан байна. Тус аж ахуйн нэгжүүдийн өөрийн гурилын үйлдвэртээ тушаасан улаанбуудайн хэмжээг тогтоохдоо зөвхөн толгой компаний захирал болон тариалангын бригадын дарга /нэг компанийн ажилтан хооронд/ хооронд байгуулсан гэрээг үндэслэн урамшууллын хэмжээг тогтоосон байна. Тус сангийн ажилтнууд нь урамшуулал авахаар хүсэлтээ ирүүлсэн ААН-үүдийн мэдээллийг зөвхөн гурилын үйлдвэртэй тооцоо нийлсэн акт, байгуулсан гэрээгээр баталгаажуулж байгаа нь урамшууллыг хуурамч материал бүрдүүлэн авах, ААН-үүд өөрсдийн гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайн хэмжээг хуурамчаар өсгөж урамшуулал авах өндөр эрсдэлтэй байна.

Өөрийн гурилын үйлдвэрт буудай нийлүүлсэн ААН-үүдийн мэдээ:

№	Аж ахуйн нэгжийн нэр	Гурилын үйлдвэр	Урамшуулал авсан он	Нийлүүлсэн буудай /тонн/
1	Дорнод гурил ХХК	Дорнод гурил ХХК	2013;2014;2016;2017	11,408.7
2	Хөвсгөл алтан дуулга ХХК	Хөвсгөл Алтан дуулга ХХК	2015;2016;2017	5,498.4
3	Баяндарь ХХК	Баяндарь ХХК	2013;2014	2,545.4
4	Өрхтий трейд ХХК	Өрхтий трейд ХХК	2013;2014;2015;2016;2017	2,493.0
5	Батзол ХХК	Батзол ХХК	2013;2014;2015;2016;2017	2,083.2
6	Хангай миллс ХХК	Хангай миллс ХХК	2014;2016;2017	2,066.0
7	Багахангай ХХК	Багахангай ХХК	2013;2014;2015;2016;2017	2,058.5
8	Энхбулган ХХК	Энхбулган ХХК	2013;2014;2016	1,586.3
9	Улаан од ХХК	Улаан од ХХК	2014;2015;2016;2017	1,573.8
10	Их эрхүүд ХХК	Их Эрхүүд ХХК	2015;2016;2017	1,493.1
11	Мөнхийн дуурлиг ХХК	Мөнхийн дуурлиг ХХК	2013;2014;2015	1,082.7
12	Хантай Баян ХХК	Хантай Баян ХХК	2013;2014;2015;2016;2017	911.7
13	ЭТҮ ХХК	ЭТҮ ХХК	2013	909.0
14	Хонгор агро булган ХХК	Хонгор агро булган ХХК	2014	712.5
15	Орхон мандал ХХК	Орхон мандал ХХК	2015;2016;2017	575.9
16	Хоёр богд ХХК	Хоёр богд ХХК	2013;2014	271.2
17	Баянтооройн бүрд ХК	Баянтооройн бүрд ХК	2014	200.0
18	Муку ХХК	Муку ХХК	2013	198.5
19	Хөгжил увс ХХК	Хөгжил увс ХХК	2013	189.1
20	Гурванборхууд ХХК	Гурванборхууд ХХК	2013	120.0
21	Баялаг бумбат ХХК	Баялаг бумбат ХХК	2013	65.0
22	Мөнгөт хайрхан уул ХХК	Мөнгөт хайрхан уул ХХК	2013	48.5
НИЙТ /тонн/				38,090.4
НИЙТ /мөнгөн дүн/				2,671,531,030.0

/Жич: Нэг эзэмшигчтэй боловч нэр өөр ААН-үүдийн мэдээллийг хамруулаагүй болно./

Өмнө хийгдсэн шалгалтын тайлангаас үзэхэд 30 ААН хуурамч баримт бүрдүүлэн улаанбуудайн урамшууллаас 561.1 сая төгрөг авсныг тогтоож эргэн төлүүлэх талаар акт үйлдсэнээс 405.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж 145.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Дээрх зөрчлийг судлан үзэхэд, тухайн ААН-үүд нь гурилын үйлдвэрүүдтэй буудай нийлүүлэх гэрээг байгуулан сангаас урамшууллыг авсны дараа тодорхой шалтгаануудын улмаас гэрээний үүргээ зөрчиж гурилын үйлдвэрүүдэд тохирсон буудайгаа нийлүүлээгүй байна.

Түүнчлэн урамшууллыг олгохдоо тус сан нь өртэй ААН-үүдийн өрийг өгөх урамшууллаас суутган тооцдог байна. Урамшуулал авахад бүрдүүлэх материалын жагсаалтад татварын албаны тодорхойлолтыг авсан байх бөгөөд, үүнийг урамшууллын шалгуур үзүүлэлт болгон үнэлхэд ашигладаггүй байна. Иймд хүчингүй болсон журмыг шинэчлэн батлуулахдаа, татварын өртэй ААН урамшуулал авах тохиолдолд татварын өрийг суутган тооцох тогтолцоог бүрдүүлэн ажиллах шаардлагатай байна.

6. Техник дундын үйлчилгээний төвүүдийн талаар:

2008 оноос хэрэгжиж эхэлсэн “Атрын III аян” хөтөлбөрийн хүрээнд өрхийн ногооны аж ахуй болон жижиг дунд газар тариалан эрхлэгчдийг дэмжих зорилготойгоор ҮХАА-н сайдын болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар “Техникийн үйлчилгээний дундын төв”-үүдийг /ТҮДТ/ байгуулж, 2009-2011 онуудад нийт 16 аймаг /30 гаруй сум /-дын ЗДТГ, Халх гол төсөл, Улаанбаатар хотын Аймаг дундын отрын бэлчээрийн захиргаатай лизингийн гэрээ байгуулан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн 4,986.1 сая төгрөгийн 183 ширхэг техник, тоног төхөөрөмжүүдийг хуваарилан олгохын зэрэгцээ ОХУ-ын зээлээр \$1,944,880.00 ам долларын 80 ширхэг техник, тоног төхөөрөмж, нийт 270 ширхэг техникүүдийг 3 жилийн хугацаанд буцаан төлөх нөхцөлтэйгээр олгосон байна.

Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газарт “Техник, үйлчилгээний дундын төв” байгуулж, эрхлэгч томилж, механик, засварчин зэрэг орон тоо ажиллуулж, газар тариалан, тариа ногооны аж ахуй эрхлэгчдэд төлбөртэй үйлчилж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулсан бөгөөд, тэдгээртэй байгуулсан гэрээгээ цаг хугацаанд нь дүгнээгүй, өр зээлээ төлүүлэх талаар анхаараагүйгээс үүргийн гүйцэтгэл хангагдахгүй болж, 3.9 тэрбум төгрөгийн зээлийн авлага хуримтлагджээ.

Аймгуудын ЗДТГ-аас ААН, иргэдтэй гэрээ байгуулан тараагдсан техникүүдийн зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байгаа нь тухайн үед энэ ажлыг хариуцаж байсан ажилтнууд сонгууль бүрийн дараа ихэнх нь солигдож байгаагаас зээлдэгчидтэй байгуулсан гэрээний үүрэг биелүүлэхгүй болж, эргэн төлөлт хийгдэхгүй болсон байна.

7. Сангийн өглөг, авлагын талаар:

Тариаланг дэмжих сангийн өглөгийн үлдэгдэл 2018 оны 9 дүгээр сарын 30-ний байдлаар 141.6 тэрбум төгрөг байна.

- Сангийн өглөгийн хураангуй мэдээлэл:

Ангилал	2018.09.30	2018.12.28	Тайлбар
Бэлтгэн нийлүүлэгчид өгөх өглөг	15,843,196,506.07	4,244,231,853.37	2018 оны дэмжлэг олгоход зориулсан үрийн буудай, шатахуун, техник тоног төхөөрөмжийн үнийн өглөг
ОХУ-ын техникийн өглөг	31,692,578,116.57	31,692,578,116.57	2017 он, 2018 онд ОХУ-аас оруулж ирсэн хөдөө аж ахуйн техникийн зээлийн өглөг
Урамшууллын өглөг	1,015,396,700.00	1,015,396,700.00	Эрүүгийн цагдаагийн газрын дүгнэлтийн дагуу хүнсний улаан буудайн урамшууллыг хуурамч материал бүрдүүлэн авсан иргэд ААН
Шатахууны өглөг/ОБЕГ/	1,099,063,747.94	2,394,153.34	ОБЕГ-т ОХУ болон Хятадын зээлийн техник, тоног төхөөрөмж нийлүүлэн өглөгийн тооцоог барагдуулав.
КР-1-д өглөг	26,876,233,837.07	26,876,233,837.07	Японы буцалтгүй тусламжийн КР-1, КР-2 төслийн хүрээнд үүссэн өглөг
КР-2-д өглөг	5,227,741,423.46	5,227,741,423.46	
Хятад зээлийн трактор 2012	9,131,430,933.92	9,131,430,933.92	Хятадын зээлийн техник худалдан авсан тариаланч аж ахуй нэгж, иргэдийн эргэн төлөлтөө буудай болон урамшууллаар төлснөөр бий болсон төлбөр
МУХСанд өгөх өглөг	27,311,147,633.48	21,053,524,353.18	МУХСангийн өглөгөөс 2018.12.03-нд 100.0 сая төгрөг, 2018.12.28-нд 604.2 сая төгрөг, нийт 704.2 сая төгрөгийн төлөлт хийв.
Сангийн яаманд өглөг	23,400,000,000.00	-	Төсвийн зээлийг 2018.11.22-нд 9,287.4 сая төгрөг, 2018.12.27-нд 14,112.5 сая төгрөг төлж төлбөрийг 100% барагдуулсан
Дүн	141,596,788,898.51	99,243,531,370.91	

- Сангийн авлагын хураангуй мэдээлэл:

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 2005-2018 оны хооронд нийт 585.3 тэрбум төгрөгийн дэмжлэгийг хүнсний буудай, үрийн буудай, тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис, шатахуун зэргээр тариалан эрхлэгч иргэд, ААН-үүдэд олгосон бөгөөд сангийн нийт авлага 2018 оны 9 сарын 31-ний байдлаар 132.0 тэрбум төгрөг байна.

Ангилал	2018.09.30	2018.12.28	Тайлбар
Газар тариалан эрхлэгчдээс авлага	75,372,074,728.03	59,512,491,614.03	Хугацаа хэтэрсэн болон 2018 онд төлөгдөх 37,716.6 сая төгрөгийн авлагаас 15,388.6 сая төгрөг нь намрын ургацаас тушаасан буудайгаар, 470.8 сая төгрөг харилцах дансанд, нийт 15,859.5 сая төгрөгөөр буурав.
ОХУ-ын техникийн авлага	21,228,770,485.49	21,228,770,485.49	ОХУ-ын техникийн зээлийн авлага нь 2017 оноос үүссэн бөгөөд 2019 он-2023 онд төлөгдөх хугацаандаа зээлийн авлага байна.
Гурилын үйлдвэрээс авах авлага	22,102,234,768.80	19,012,712,440.80	Гурилын үйлдвэрээс авах авлага нь 2007 он-2018 онд үүссэн бөгөөд үүнээс 3,089.5 сая төгрөг төлөгдөж 19,012.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй болов. Үүний 18,519.0 сая төгрөгт шүүхийн шийдвэр гаргуулан эвлэрлийн гэрээ байгуулсан бөгөөд үлдсэн 493.6 сая төгрөгийн авлага нь хуваарийн дагуу төлөгдөж байна.
Техник дундын үйлчилгээний төв	3,879,675,230.47	3,250,275,230.47	ТДҮТ –ийн 3,879.6 сая төгрөгийн авлага байснаас Сангийн яамны аудитын зөвлөмж, ТЭДС-ийн өмч хамгаалах комиссын дүгнэлтийг үндэслэн 2,707.9 сая төгрөгийн элэгдэл байгуулан үлдэх өртөг 542.0 сая төгрөгөөр худалдан борлуулах шийдвэр гаргуулахаар бэлтгээд байна.
Жимс, чацаргана төслийн зээл	9,266,516,951.53	9,266,516,951.53	2009 он-2018 онд олгосон жимсний төсөл, суулгац, плантаци, кластерийн зээлийн авлага бөгөөд 3,233.9 сая төгрөг нь гэрээний дагуу хугацаандаа зээлийн үлдэгдэл байна.
Хувь хүнээс авах авлага	130,358,368.53	80,358,368.53	Орон сууцны зээлийн үлдэгдлээс 2 иргэний 50.0 сая төгрөг төлөгдөж 80.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй болоод байна.
Нийт дүн	131,979,630,532.85	112,351,125,090.85	

• Хугацаа хэтэрсэн авлагын дэлгэрэнгүй мэдээлэл:

Он	Бордоо	Хүнсний буудай /гурилын үйлдвэр/	УХБ	Үрийн буудай	Шатахуун	Тоног төхөөрөмж
2005	-	-	-	-	-	-
2006	-	-	-	154,251,300.0	-	-
2007	-	-	12,545,000.0	59,631,000.0	-	-
2008	-	-	-	212,928,562.0	23,380,000.0	-
2009	-	-	37,629,752.0	2,051,147,476.0	2,491,549,191.3	-
2010	-	-	30,164,300.0	319,974,080.0	1,390,331,437.9	-
2011	-	-	588,843,961.6	608,024,128.5	2,268,580,096.9	22,533,806,800.0
2012	-	9,729,733,945.4	634,185,293.1	-	-	-
2013	41,892,900.0	772,564,400.0	298,941,249.4	381,653,572.2	223,211,231.7	-
2014	40,422,241.2	804,434,196.0	308,202,890.0	438,399,982.8	333,047,998.0	-
2015	499,425,134.0	485,093,053.0	573,170,806.0	470,105,337.0	717,320,448.2	-
2016	439,323,569.50	273,564,550.00	1,221,191,320.56	3,335,692,985.00	881,842,707.00	-
2017	797,560,863.00	8,088,645,467.90	1,382,299,750.95	3,318,249,135.66	2,799,323,379.79	-
2018	-	-	-	-	-	-
Нийт	1,818,624,707.66	20,154,035,612.30	5,087,174,323.52	11,350,057,559.16	11,128,586,490.75	22,533,806,800.00
НИЙТ ХУГАЦАА ХЭТЭРСЭН АВЛАГА - 72.1 тэрбум төгрөг						

/Хугацаа хэтэрсэн зээлтэй ААН-үүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав./

Тус сангаас олгосон үндсэн дэмжлэгүүдийн эргэн төлөлт, түүнд тавих хяналт туйлын хангалтгүй бөгөөд 2018 оны 9 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар нийт 132.0 тэрбум төгрөгийн авлагатай байгаагаас 54.6% буюу 72.1 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн чанаргүй зээл эзэлж байна.

8. Тариаланг дэмжих сангийн хууль, эрх зүйн орчин:

Тариаланг дэмжих сан нь дараах хууль тогтоомж, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

- Тариалангийн тухай хууль (2016 он)
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль (2006 он)
- Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоол “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”
- Хүнсний буудайн тонн тутамд мөнгөн урамшуулал олгох хэмжээг тогтоох тухай ЗГ-ын тогтоолууд (жил болгон шинэчлэн гардаг)
- Хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 114 дүгээр тушаалаар баталсан “Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дүрэм”
- ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын 2010 оны хамтарсан тушаалаар баталсан “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгоход баримтлах журам”
- ХХААХҮ-ийн сайдын хүнсний болон үрийн буудай худалдан авах, худалдан борлуулах үнэ тогтоох тухай тушаалууд
- ТЭДСангийн захирлын 2015 оны А/107 дугаар тушаалаар батлагдсан “Тариалан эрхлэгч иргэн, хуулийн этгээдэд дэмжлэг үзүүлэх журам” гэх мэт.

Тариалан эрхлэлтийг дэмжих сантай холбоотой тогтоол, тушаалуудыг авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Он	Сайдын тушаал		ТНБД		Удирдах зөвлөл		Гүйцэтгэх захирлын тушаал	
	гарсан	түүвэрт орсон	гарсан	түүвэрт орсон	гарсан	түүвэрт орсон	гарсан	түүвэрт орсон
2005	14	11	3	3	0	0	12	2
2006	17	11	6	5	0	0	16	4
2007	19	14	0	0	0	0	13	3
2008	45	36	2	1	0	0	34	9
2009	45	30	12	9	23	7	58	5
2010	41	37	1	0	26	8	71	9
2011	28	20	3	1	17	6	64	17
2012	22	22	0	0	14	6	75	16
2013	22	20	2	0	21	15	70	17
2014	14	10	4	5	23	10	46	13
2015	16	14	1	1	8	4	73	70
2016	22	18	0	0	9	3	119	55
2017	10	9	1	0	7	2	53	21
2018	18	18	0	0	9	4	124	35
Нийт	333	270	35	25	157	65	828	276

/Сантай холбоотой тушаал, шийдвэрүүдийн хуулбаруудыг хавсаргав/

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагаатай холбоотой тушаалаас гадна Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор батлагдсан “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2-т заасны дагуу “... сан нь үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэг чиг үүрэгтэй” болон Хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 114 дүгээр тушаалаар батлагдсан “Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.14-т “Сангийн хөрөнгийг ... зориулалтаар зарцуулна...” гэсэнтэй нийцэхгүй дараах тушаалууд гарсан байна. Үүнд:

№	Сайдын тушаал		
	Огноо	Дугаар	Утга
Орон сууц, ажлын байрны барилгын зардалд:			
1	2007.11.29	142	ХХААЯ-нд ажиллаж байгаа албан хаагчдад орон сууцны дэмжлэгийг 5 жилийн хугацаатай, 155.0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэсэн.
2	2008.09.05	163	Албан ажлын болон ажилтнуудын орон сууцны барилга бариулах тухай. Барилгын ажлыг ТЭДС-ийн хөрөнгийг банкинд хадгалуулсан хүүгийн орлогоос гарган, эргэн төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн тушаалын 4-т “... ажлын байрны зарим хэсгийг ТЭДС-д эзэмшүүлэх ...” гэж шийдвэрлэжээ. /нийт 1,634.7 сая төгрөгийг буцааж 2013 онд төлсөн байв/

3	2009.08.03	175	ХХААХҮЯ-ны барилгын өргөтгөлийн зураг төсөл, судалгаа, барилгын өргөтгөлийн эскиз, ажлын байр барих талбай цэвэрлэх зэрэг нийт 137.6 сая төгрөгийн санхүүжилтийг ТЭДС-аас гаргахаар шийдвэрлэсэн.
4	2009.12.08	274	ХХААХҮЯ-ны шинээр барих өргөтгөлийн барилгын суурийн ажил гүйцэтгэх арга хэмжээний зардлыг 1,296.3 сая төгрөгийг ТЭДС-ийн хөрөнгө оруулалтын төсөв болон трактор, дагалдах хэрэгсэл, тоног төхөөрөмжийг худалдан борлуулсны орлогоос санхүүжүүлэхийг ТЭДС-д даалгасан.
Сургалт, семинар, шагналд:			
1	2008.01.24	16	Завхан, Төв аймагт зохион байгуулсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил”-д зориулан хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн сургалт, семинарын нийт 8.9 сая төгрөгийн зардлыг ТЭДС-ийн хөрөнгийг банкинд хадгалуулсан хүүгийн орлогоос гаргахаар шийдвэрлэсэн.
2	2008.04.04	70	Баянхонгор аймгуудад зохион байгуулсан “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил”-д зориулан хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн сургалт, семинарын нийт 4.0 сая төгрөгийн зардлыг ТЭДС-ийн хөрөнгийг банкинд хадгалуулсан хүүгийн орлогоос гаргахаар шийдвэрлэсэн.
3	2008.02.26	45	“Атрын 3 дахь аян” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж буй “Тариаланчдын ургацын далай холбооны II чуулга уулзалт”-ын 10.0 сая төгрөгийн зардлыг ТЭДС-ийн банкинд хадгалуулсан хөрөнгийн хүүгийн хуримтлалаас гаргахаар шийдвэрлэсэн.
4	2008.09.17	170	ХААИС-ийн Агробиологийн сургуульд ХАА-н усан хангамж, усалгаатай газар тариалангийн хичээлийн кабинетыг шинэчлэн тоноглоход зориулж 4.0 сая төгрөгийг ТЭДС-ийн Усны хяналтын зардлаас гаргахаар шийдвэрлэсэн.
5	2008.10.20	15	Тус тушаалын 1-т Ургацын баярт зориулан тус яамнаас санхүүжүүлэх зардлын төсвийг хавсралтын дагуу 15.8 сая төгрөгөөг баталсугай. 2-т Батлагдсан төсвийн дагуу ургацын баярын арга хэмжээг санхүүжүүлэхийг ТЭДС-д зөвшөөрсүгэй гэж шийдвэрлэсэн.
6	2009.07.15	168	“Атрын 3 дахь аян” тариалангийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд ОХУ-ын Эрхүү хотод зохион байгуулсан сургалтын зардлын үлдэгдэл 15.6 сая төгрөгийг ТЭДС-аас гаргахаар шийдвэрлэсэн.
7	2010.05.20	A129	БНХАУ-ын НББ-ийн туршлага судлах, “Төсөвт байгууллагын НББ, Санхүүгийн тайлан гаргалт” сургалтад хамруулах, сургалтад хамрагдах хүмүүсийн зардал 32.0 сая төгрөгийг ТЭДС-ийн сургалтын зардлаас гаргах тухай. <u>/ХХААХҮЯ-6 хүн, ТЭДС-1 хүн, аймгийн ХХААЖДҮГ-11, ХЯБ хөтөлбөрийн болон МЭЭММАА33 төслийн нябо, СЯ-ны 2 хүн, нийт 22 хүн/</u>
8	2012.02.02	A22	“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч” шагналын нийт 90.0 сая төгрөгийг дутагдаж буй 57.0 сая төгрөгийг ТЭДС-аас гаргахаар шийдвэрлэсэн.
9	2012.01.11	A60	Ажлын хэсэг байгуулах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай. “Хангайн бүс-2012” хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн техник, тоног төхөөрөмжийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулахад шаардагдах нийт 20.1 сая төгрөгийн 16.5 сая төгрөгийг ТЭДС-аас гаргахаар шийдвэрлэсэн.
10	2014.04.24	A56	Төв, Булган, Сэлэнгэ, Хөвсгөл аймгуудад тариалалтын бэлтгэл ажлын явцтай танилцаж, “Газар тариалангийн тогтвортой хөгжил” хөтөлбөрийн төсөлд санал авах, зорилгоор орон нутагт ажиллах

			ажлын хэсгийн 8.4 сая төгрөгийн зардлыг ТЭДС-аас гаргахаар шийдвэрлэсэн. Тус ажлын хэсэгт яамны 5 хүн багтсан.
11	2014.09.22	A109	Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орнуудын ХААС нарын 3-р хурал, “Агро-Иннотек” үзэсгэлэнд оролцох тухай. Тушаалын 4-т “Айлчлалын албан ёсны бүрэлдэхүүнд орсон Сайдын зөвлөх Б.Саруул , ТЭДС-ийн төлөөлөгчдийн томилолтоор ажиллахтай холбогдсон зардлыг ТЭДС-аас санхүүжүүлэхээр тусгасан.
12	2015.01.08	A02	ХБНГУ-ын Берлин хотноо 2015.01.16-25-ны өдрүүдэд зохион байгуулагдах ОУ-ын “Ногоон долоо хоног” үзэсгэлэн яармаг”, “Хүнс, хөдөө аж ахуйн сайд нарын дээд хэмжээний чуулга уулзалт-2015”, “Тогтвортой газар тариалан төсөл”-ийн хүрээнд зохион байгуулагдах үр сортын сургалтад оролцох ХХААЯ-ны 3 төлөөлөгчийн томилолтын 4.9 сая төгрөгийн зардлыг ТЭДС-аас гаргахаар тусгасан.
13	2015.07.08	A96	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг шалгах, хүлээн авах, үнэлгээ, засвар хийх сургалтын 18.3 сая төгрөгийг ТЭДС-аас гаргах тухай.
14	2016.01.14	A09	ОХУ-д ажиллах багийн 12.8 сая төгрөгийн зардлыг хүнсний хангамжийг нэмэгдүүлэх КР-1 төслийн хуримтлалын сангийн хөрөнгийг банкинд хадгалуулсан хүүгийн орлогоос санхүүжүүлэхийг ТЭДС-д даалгасан. /3 хүн/

Илэрсэн зөрчил, дутагдлууд:

- Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоол (Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам) нь 2004 онд батлагдсан Тариалангын тухай хуулийг үндэслэн батлагдсан байх бөгөөд, тус хууль нь 2016 онд шинэчлэгдэн батлагдсан байна. Үүнтэй холбоотойгоор сангийн үйл ажиллагаандаа мөрддөг үндсэн журмыг шинэчлэн батлаагүй бөгөөд 2016 оноос хойш хүчин төгөлдөр бус журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.
- Хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 114 дүгээр тушаалаар батлагдсан “Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дүрэм” нь мөн 2016 онд хууль шинэчлэн батлагдсанаар хүчин төгөлдөр бус болсон байна.
- ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын 2010 онд хамтран баталсан “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгох журам” нь ЗГ-ын 2009 оны 350 дугаар тогтоолыг үндэслэн баталсан байх бөгөөд тус тогтоолыг ЗГ-ын 2012 оны 77 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна. ЗГ-ын 350 дугаар тогтоол хүчингүй болсноор “Хүнсний буудайнд урамшуулал олгох тухай журам” хүчингүй болсон бөгөөд журмыг шинэчлэн батлуулаагүй буюу 2012 оноос хойш хүчингүй болсон журмын хүрээнд ажиллаж ирсэн байна.
- Тариаланг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагаа болох санхүүгийн дэмжлэг буюу хүүгүй зээлдүүлэх үйл ажиллагаанд баримтлах журам, гарын авлага байхгүй бөгөөд, хүчингүй болсон журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

9. Сангийн хөрөнгийн талаар:

Алтан дорнод монгол ХХК-аас татварын өрөнд шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгийн талаар:

Алтандорнод Монгол ХХК нь татварын өрөө барагдуулахаар өөрийн эд хөрөнгийг санал болгосноор МУ-н Засгийн газрын 2013 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 30 дугаар тэмдэглэлд санал болгосон хөрөнгө, объектуудын үнэлгээ, өмчлөлийн асуудлыг нягталж төрийн өмчид хүлээн аах ажлыг зохион байгуулахыг Төрийн өмчийн хорооны даргад, татварын өрийг барагдуулахыг ТЕГ-ын даргад тус тус үүрэг болгосон байна. Үүний дагуу Төрийн өмчийн хорооны 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 555 дугаар тогтоол гарч Алтандорнод Монгол ХХК-ын эзэмшлийн техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, хангамжийн “Улаанбаатар бааз”-ын 15.5 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг, Востокнефтваз ХХК-ийн ХУД-ийн 3-р хороонд байрлах “Нефьт хангамжийн бааз”-ын 25.3 тэрбум төгрөг, Ршааг дахь “Нефьт болон хий боловсруулах үйлдвэр”-ийн 14.0 тэрбум төгрөгийн, нийт 54.8 тэрбум төгрөгөөр үнэлэгдсэн эд хөрөнгийг Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн балансад шилжүүлэхээр тогтоосон байдаг.

Тухайн үед дээрх хөрөнгүүдийн үнэлгээтэй холбоотой асуудлаар яамдуудын хамтарсан ажлын хэсэг гарган шалгасан боловч, ЗГ-ын тэмдэглэлд тусгагдсан үнэлгээг ахин нягтлах ажлыг зохион байгуулахгүйгээр өндөр үнээр хөрөнгийг тооцож татварын өрөнд суутгасан зөрчил гарчээ.

Сангийн балансад бүртгэлтэй бусад үл хөдлөх хөрөнгийн талаар:

Тус сан нь үндсэн дэмжлэг, буудайн урамшуулал олгохоос гадна, өөрийн эзэмшлийн элеватор, агуулахуудыг ашиглан тариалан эрхлэгчдэд тарианы хогт хольцыг цэвэрлэх, хатаалга, сэлгэлт, ачилтын үйл ажиллагааг эрхэлдэг. Сангуудын өнгөрсөн жилүүдийн тайлан, сангийн захирлын тушаалаас харахад тус үйлчилгээний хөлсийг чөлөөлөх эсхүл, хэт багаар буюу хөрөнгийн ашиглалтын зардлаас багаар тогтоож ирсэн байна.

ХОЁР. ИЛЭРСЭН ЗӨРЧЛҮҮДИЙН ХУРААНГУЙ

Худалдан авах ажиллагаа:

- 1) Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам нь 2009-2012 оны хооронд тус сангийн худалдан авалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулдаг байсан бөгөөд 2012 оноос эхлэн шатахуун, ургамал хамгааллын бодис үрийн буудай, хүнсний буудайн худалдан авалтыг сан өөрөө хариуцан зохион байгуулдаг болсон байна. Тус яамнаас 2009-2018 оны хооронд нийт 60 удаагийн тендерийн сонгон шалгаруулалтыг хийж нийт 58.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй гэрээг нийлүүлэгч ААН-үүдтэй байгуулснаас нийт 40.3 тэрбум төгрөгтэй холбоотой 30 тендер нь худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж хийгдсэн байна.
- 2) 2010 онд Сангийн яамнаас “Үр тариа хураах комбайн худалдан авах” тендер шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтийг хянан үзээд 2010.03.22-ны өдрийн 5/1244 тоот албан бичигт захиалагчийн гэрээ байгуулах шийдвэр хууль,

журамд нийцэхгүй байгааг дурдаад, дахин үнэлгээ хийхийг мэдэгдсэн байтал зөрчлийг арилгалгүй "хүчин чадлын хувьд тохиромж муутай, ашиглалтын зардал өндөр" гэсэн тендерийн баримт бичиг тусгаагүй шалтгаанаар хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерээс татгалзаж, уг тендерээс 397 сая төгрөгөөр илүү үнэ санал болгосон "Гацуурт" ХХК-тай гэрээ байгуулсан нь хуулийн 28 дугаар зүйлийн 28.7.4-т заасныг зөрчсөн байна.

- 3) 2011 онд "Үр тариа хураах комбайн худалдан авах" тендерийн үнэлгээний дүгнэлтийг Сангийн яамнаас хянан үзээд 2011 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 5/1409 тоот албан бичгээр "Баяндулаан-Уул" ХХК-ийн ирүүлсэн татварын тодорхойлолтоор өртэй байгаа нь шаардлага хангахгүй гэж мэдэгдсэн байхад хууль зөрчиж гэрээ байгуулсан.
- 4) 2016 онд Сангийн яамнаас "Нийлмэл бордоо нийлүүлэх" тендер шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтийг хянан үзээд тендер шалгаруулалтыг ямар журмаар зохион байгуулсан нь тодорхойгүй, үндэслэл байхгүй, тендер шалгаруулалтыг 17 хоногийн хугацаатай зарласан нь хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-т заасныг, багц тус бүрээр үнэлгээ хийгээгүй нь хуулийн 8.7.3-т заасныг тус тус зөрчсөн, мөн тендерийн баримт бичигт зарим шалгуур үзүүлэлтийг хэт өндөр заасан, түншлэлээр тендер оролцохыг хориглосон, ямар төрлийн тусгай зөвшөөрөл шаардсан тодорхойгүй нь өрсөлдөөнийг хязгаарлаж улмаар шаардлагад нийцсэн тендер ирүүлэх боломжийг хаасан байх тул тендер шалгаруулалтыг дахин зохион байгуулахыг 2016 оны 6/244 тоот албан бичгээр мэдэгдсэн байна. Захиалагч дээрх зөрчлийг арилгалгүй, хууль зөрчиж нийт 4 багцад нийт 8,9 тэрбум төгрөгийн шууд гэрээ байгуулсан байна.
- 5) 2009 онд зохион байгуулсан "Нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх" тендер шалгарсан "Мөнх ногоон тал" ХХК-ийн ирүүлсэн тендер нь захиалагчийн тендерийн баримт бичигт заасан ижил төстэй ажлын туршлагыг нотлох баримт ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан.
- 6) "Жимс, жимсгэний суулгац авах" тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд "Глобал бридж" ХХК-ийн техникийн тодорхойлолтод санал болгосон суулгацын нас шаардлага хангахгүй гэж дүгнэсэн хэрнээ гэрээ байгуулсан.
- 7) "Үр тариа хадгалах элеватор худалдан авах" тендер "Гурил тэжээл Булган" ХК-ийн эзэмшлийн элеваторыг нийлүүлэхээр "Бэрэн групп" ХХК оролцохдоо тендерийн баримт бичгээ "Гурил тэжээл Булган" ХК-ийн материалаар бүрдүүлсэн байхад шалгаруулсан./тус худалдан авсан элеваторыг 2007 он буюу буцаан худалдан авахаас 2 жилийн өмнө хувьчилсан байна/
- 8) "Хөдөө аж ахуйн чиргүүл, дүүжин машин худалдан авах" тендер шалгарсан "Агромаш" ХХК нь захиалагчийн тендерийн баримт бичигт заасан туршлагын талаарх мэдээлэл ирүүлээгүй байхад гэрээ байгуулсан.
- 9) "Нийлэг хальсан хүлэмж нийлүүлэх" тендер захиалагчийн тендерийн баримт бичгийн ижил төстэй ажлын шаардлага хангахгүй "Нью телеком" ХХК-ийг шалгаруулсан.
- 10) 2011 онд зохион байгуулсан "Төмс хүнсний ногооны өрхийн аж ахуйн багаж хэрэгсэл худалдан авах" тендер захиалагчийн тендерийн баримт бичигт

заасан борлуулалтын орлогын хэмжээнд хүрэхгүй “Ирээдүй энерги” ХХК-ийг шалгаруулсан.

- 11) “ХАА-н чиргүүл, дүүжин машин худалдан авах” тендерт шалгарсан “Онлайн датен систем” ХХК нь захиалагчийн тендерийн баримт бичгийн Олон Улсын ISO стандартын гэрчилгээ, Мэргэжлийн байгууллагын тодорхойлолт ирүүлэх шаардлагыг хангахгүй байхад гэрээ байгуулсан.
- 12) 2017 онд зохион байгуулсан “Дунд оврын трактор, хүнсний ногооны иж бүрдэл техник нийлүүлэх” тендерт шалгарсан “Дорнод газар” ХХК-ийн санал нь захиалагчийн тендерийн баримт бичигт заасан ижил төстэй ажлын шаардлага хангахгүй, мөн тус тендерийн Багц 4-т шалгарсан “Анхны анжис” ХХК-ийн борлуулалтын орлогын хэмжээ хүрэхгүй, ижил төстэй ажлын туршлагын шаардлага хангахгүй байхад тус тус шалгаруулсан нь хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасныг зөрчсөн байна.
- 13) Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас 2012-2014, 2018 онуудад “Үр ариутгалын болон ургамал хамгааллын бодис нийлүүлэх”, “Бордоо нийлүүлэх”, “Шатахуун нийлүүлэх” сонгон шалгаруулалтуудыг харьцуулалтын аргаар зохион байгуулсан нь хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.” гэж заасныг зөрчсөн байна. Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэж заасан бөгөөд дамжуулан зээлдүүлэх зээлийн үйл ажиллагаа нь энэ хуульд хамаархааргүй байна.
- 14) Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь 2018 оноос худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим системд нэвтрэх эрх авч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг олон нийтэд мэдээлж ажиллаж эхэлсэн байх бөгөөд 2009-2017 онуудад зохион байгуулсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний талаар олон нийтэд зарлан мэдээлээгүй нь хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.5-т дах хэсэгт заасныг тус тус зөрчсөн, мөн дээрх онуудад худалдан авах ажиллагааны цахим системд тендерийн урилга, үр дүнгийн талаар мэдээлээгүй нь хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4-т “Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан вэб хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүр мэдээлнэ” гэж заасныг зөрчсөн байна.
- 15) ХХААХҮ-ийн сайдын тушаалаар тогтоосон үнээс хамааран 2005-2013 оны хооронд үрийн буудай худалдан авах, борлуулах үйл ажиллагаанаас цэвэр дүнгээр ашигтай ажиллаж байсан бол 2014-2018 оны хооронд тогтмол алдагдалтай ажилласан байна. Тухайлбал, 2018 онд санд худалдан авах үрийн буудайн үнийг чанараас нь хамааран тонн тутамд 780-830 мянган төгрөг байхаар тогтоосон бол сангаас худалдан борлуулах үнийг тонн тутмыг 570-620 төгрөг байхаар тогтоосон байна. Энэ нь сан буудайн борлуулалтаас 2018 онд тонн тутамд 210 мянган төгрөгийн алдагдал буюу нийт 252.0 орчим сая төгрөгийн цэвэр алдагдал хүлээх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 16) ХХААХҮ-ийн сайдын тушаалаар тогтоосон сангийн өрөнд суутган авах болон худалдан борлуулах буудайн үнийг санд буудай худалдан авах үнээс тонн

тутамд 10-50 мянган төгрөгөөр багаар тогтоосон байна. Үүнээс үүдэн сан нь жил тутам буудайн борлуулалтаас алдагдал хүлээж ирсэн бөгөөд сангийн өглөг, авлага жил тутам өсөхөд гол нөлөөг үзүүлсэн байна. Тус сан нь хүнсний буудайн хөдөлгөөнийг худалдан авсан үнээр баталгаажуулан бүртгэдэггүйгээс үүдэн буудайн борлуулалтаас жил болгон хэдэн төгрөгийн алдагдал хүлээснийг тооцож гаргах боломжгүй нөхцөл байдлыг бий болгосон байна.

Санхүүгийн дэмжлэгийн талаар:

- 17) Тус сангаас олгосон үндсэн дэмжлэгүүдийн эргэн төлөлт, түүнд тавих хяналт туйлын хангалтгүй бөгөөд 2018 оны 9 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар нийт 132.0 тэрбум төгрөгийн авлагатай байгаагаас 54.6% буюу 72.1 тэрбум төгрөг нь хугацаа хэтэрсэн чанаргүй зээл эзэлж байна. Дээрх хугацаа хэтэрсэн авлагуудтай холбоотой 45.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулах талаар шүүхийн шийдвэр гарсан байхад 2010 оноос хойших хугацаанд ердөө 10.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийг бодитоор барагдуулж дуусгасан байна.
- 18) Хүнс, хөдөө аж ахуйн сайдын /сайд Д.Тэрбишдагва/ 2007 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн “Технологийн шинэчлэлд дэмжлэг үзүүлэх тухай” 98 дугаар тушаалаар газар тариалангийн үйлдвэрлэлд хийгдэх, технологийн шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор 2000 ширхэг сүрэл цацах РС-2М төхөөрөмжийн үнэ 186,920,800 төгрөгийг 100.0 хувь, 80 ширхэг КПЭ-3.8 сийрүүлүүрт тоноглох цагирган булны үнийн 50.0 хувь болох 160,000,000 төгрөгийг тус тус чөлөөлж, хөнгөлөн үр тарианы үйлдвэрлэл тогтвортой эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдэд гэрээ байгуулан зээлээр олгожээ. Дээрхи тоног төхөөрөмжийн хөнгөлсөн буюу чөлөөлсөнөөс үүссэн үнэ 346,920,800 төгрөгийг сангийн хөрөнгийг байршуулсан хүүгийн орлого болон бусад эх үүсвэрээс 2010 онд багтаан бүрдүүлэхийг Тариаланг дэмжих сан /Ч.Пэрэнлэй/-д даалгасан шийдвэр гаргажээ. Сангийн данснаас үзэхэд дээр дурьдсан техник, тоног төхөөрөмжийн үнийг чөлөөлсөн, хөнгөлсөн эх үүсвэрийг нөхөн бүрдүүлсэн талаар санхүүгийн тайланд тусгайлан бүртгэж харуулсан зүйл байхгүй байлаа. Гэтэл үнэ хөнгөлсөн, чөлөөлсөнтэй холбоотойгоор үүссэн алдагдлыг ямар эх үүсвэрээс яаж, нөхөж бүрдүүлсэн нь тодорхойгүй орхижээ.
- 19) ҮХААСайдын 2014 оны А/87 тоот тушаалаар Японы Засгийн газрын КР-2 төслийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийн үнийг бууруулснаас тайлант онд 287,143.9 мянган төгрөгийн үнэ бүхий төмс, хүнсний мотоблокийг 62,400.0 мянган төгрөгөөр борлуулж, 224,743.9 мянган төгрөгийн алдагдал хүлээсэн байна.
- 20) Сангийн хөрөнгөөс ХХААХҮСайдын 2013 оны А/85 тоот тушаалаар “Батламж” гарган 2 аж ахуйн нэгжийг төмсний иж бүрдэл 14,075.8 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжөөр шагнаж урамшуулсан нь Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор баталсан “Тариаланг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-ын

27.5-д Сангийн хөрөнгөөр хандив өргөх, төрөл бүрийн арга хэмжээг ивээн тэтгэх, санхүүжүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

- 21) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайгийн 2008 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 45 тоот тушаалаар ХААИС болон 5 аймгийн 8 сургуульд 17,190,000 төгрөгийн техник, тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хуваарилж нийлүүлсэн байна.
- 22) Монгол улсын 2011 оны төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Төсвийн зээл олгох тухай Засгийн газрын 2011 оны 365 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарын баталсан “Улсын нөөцөд хүнсний улаан буудай худалдан авах”-д зориулан олгох 35.0 тэрбум төгрөгийн зээлийг 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 123 тоот гэрээний дагуу Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд улсын төсвөөс эргүүлэн төлөх нөхцөлтэйгээр 1 жилийн хугацаатай хүүгүйгээр олгосон байна. 2011 онд нийт 190,828.8 тонн буудай худалдан авсаны 100,000 тонныг дээр дурдсан улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан бол үлдэх хэсгийг ямар нэг шийдвэргүй, өөрийн хөрөнгийн боломжоос давсан худалдан авалт хийсэн байна. Аж ахуйн нэгжүүдээс худалдан авсан буудайн төлбөрийг төлөх боломж хязгаарлагдмал байсны улмаас 2011 оны оны эцэст үүссэн өрийг барагдуулах үүднээс Төрийн банкнаас сарын 1.8 хувийн хүүтэй 6.5 тэрбум төгрөгийн зээл авч зээлийн хүүд **119.3** сая төгрөг төлсөн нь сангийн алдагдал болжээ. 2011 оны 190,828.8 тонн хүнсний буудайг 66.8 тэрбум төгрөгөөр худалдан авсан боловч зөвхөн 55,740.7 тонныг худалдан авсан үнээр буюу 19.5 тэрбум төгрөгөөр, 102,233.6 тонныг 280.0 мянган төгрөгөөр борлуулж 125 тонныг үрийн будааны зориулалтаар 600.0 мянган төгрөгөөр, гэрээт аж ахуйн нэгжүүдийн нийлүүлэлтээс дутагдуулсан 736.2 тонныг 400.0 мянган төгрөгөөр тус тус тооцож нийт 158,835.2 тонн будааг 52,804.2 сая төгрөгөөр борлуулж **31.993.6 тонн буудайг дутагдуулсан байна.** Борлуулалтын тайланд нийт 61,772.8 тонн будааг сэлгэн хадгалуулахаар зарлага болгосон ба үүнээс 31.993.6 тонн буудай нь энэ дүнд орж тооцогдсон гэж тайлбарлаж байгаа боловч энэ буудай нь хэдэн оны үлдэгдэл болох нь тодорхойгүй, нэгжийн үнийн дүн болон орлого болгосон нийт үнийн дүнг бичээгүйгээс шалтгаалж тодорхойлох боломжгүй байна. Тайлангийн зөрүүгээр үнэ бууруулан борлуулсан 102,233.6 тонн буудайнаас 7.156,4 сая төгрөгийн алдагдал хүлээж, тооцоо нийлж баталгаажуулаагүй, /дутагдуулсан/ 31.993.6 тонн буудайны үнээс 11.197.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх боломжийг алдсанаар тайлангийн хугацаанд нийт **18,354.2 сая төгрөгийн алдагдал** хүлээсэн байна.
- 23) Тус сан нь 2011 оны намрын ургацаас “Гацуурт” ХХК-ийн нийт 16 аж ахуйн нэгжээс 45,407.5 тонн буудай хүлээж авсанаар тайлан гаргасан байна. Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлтэд дээрх аж ахуйн нэгжүүдийн агуулахад нийлүүлсэн 48300 тонн буудайнаас цэвэрлэх шаардлагатай 7200 тонн буудайг хасч 41,100 тонн буудайг хүлээж авсанаар тооцсон байхад Сэлэнгэ салбарын 2011 оны санхүүгийн тайланд 16 аж ахуйн нэгжээс 45,407.5 тонн буудай хүлээж авсанаар тусгасан нь орлого болгосон будааны нийт тоо хэмжээнээс 4,307.5 тонноор зөрүүтэй тооцогджээ.

24) “Гацуурт” ХХК нь ТЭДСангийн буудайнаас зөвшөөрөлгүйгээр “Хангай Миллс” ХХК-д 17.9 мянган тонн буудайг 1 тонныг нь 280.0 мянган төгрөгөөр тооцож заржээ. Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Золжаргалын баталсан 2012.12.11-ний өдрийн Буудай 12/36 тоот гэрээний дагуу “Гацуурт” ХХК-ний агуулахад хадгалагдаж байсан ТЭДСангийн өмчлөлийн 39040 тн буудайнаас дур мэдэн “Хангай миллс” ХХК-д 17970 тонн буудайг борлуулсан байна. “Гацуурт” ХХК нь дур мэдэн сангийн өмчлөлийн буудайг зарсан тул 17970 тонн буудайн / 1тонн 70.0 мянган төгрөгийн үнэтэй /үнийн зөрүү 1.3 тэрбум төгрөгийг ТЭДСангаас олгох боломжгүй бөгөөд сангийн балансаас 17970 тонн буудайг хасаж “Гацуурт” ХХК буудайгаа “Хангай миллс” ХХК-д борлуулсанаар тооцох гэсний дагуу “Гацуурт” ХХК-ний нэр дээр 2013 онд 4.2 тэрбум төгрөгийн авлага үүсгэж тус компанийн өөрийн агуулахад хадгалагдаж байсан 17970 тонн буудайг сангийн орлогоос хасч тооцохоор тооцоо хийсэн боловч эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. “Гацуурт” ХХК нь сангийн өмчлөлийн буудайнаас зарсан гэх 17970 тонн буудай нь 2011 оны ургацаас 350.0 мянган төгрөгөөр хулалдаж авсан буудай байна. Дээрх буудайны үнийг худалдаж авсан үнээр тооцож 6,289.5 сая төгрөгөөр тухайн компанийн нэр дээр авлага үүсгэж тооцохоор байхад ТЭДСангийн тайланд 4,455.0 сая төгрөгийн авлагатай байгаагаар хасалт хийж тооцоноос 1.834.5 сая төгрөгийн зөрүү үүссэн байна .Үүний 1,257.9 сая төгрөг нь буудайны үнийн зөрүүгийн алдагдал байгаа боловч Гацуурт ХХК-наар төлүүлээгүй байна.

Буудайн урамшууллын талаар:

- 25) Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 350 дугаар тогтоолыг үндэслэн ХХААХҮ сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 24/34 тоот тушаалаар “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгоход баримтлах журам”-ыг баталсан байна. Гэвч, тус журмыг гаргахдаа үндэслэсэн 2009 оны 350 дугаар тогтоолыг 2012 оны 77 дугаар ЗГ-ын тогтоолоор хүчингүй болгосон байх бөгөөд үүнтэй холбоотойгоор тус журмыг шинэчлэн батлаагүй бөгөөд, 2012 оноос хойш хүчингүй болсон журмыг баримтлан тариаланчдад урамшуулал олгох үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна.
- 26) Урамшуулал авсан ААН, иргэдийн мэдээллээс харахад улаанбуудай тарьсан ААН-үүд нь өөрсдийн гурилын үйлдвэрт /харилцан хамааралтай ААН-үүдийг оруулаагүй/ 2013-2017 оны хооронд 38.1 мянган тонн улаанбуудай нийлүүлж 2.7 тэрбум төгрөгийн урамшууллыг авсан байна. Тус аж ахуйн нэгжүүдийн өөрийн гурилын үйлдвэртээ тушаасан улаанбуудайн хэмжээг тогтоохдоо зөвхөн толгой компаний захирал болон тариалангын бригадын дарга /нэг компанийн ажилтан хооронд/ хооронд байгуулсан гэрээг үндэслэн урамшууллын хэмжээг тогтоосон байна. Тус сангийн ажилтнууд нь урамшуулал авахаар хүсэлтээ ирүүлсэн ААН-үүдийн мэдээллийг зөвхөн гурилын үйлдвэртэй тооцоо нийлсэн акт, байгуулсан гэрээгээр баталгаажуулж байгаа нь урамшууллыг хуурамч материал бүрдүүлэн авах,

ААН-үүд өөрсдийн гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайн хэмжээг хуурамчаар өсгөж урамшуулал авах өндөр эрсдэлтэй байна.

Дүрэм, журмын талаар:

- 27) Хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 114 дүгээр тушаалаар батлагдсан “Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дүрэм” нь мөн 2016 онд хууль шинэчлэн батлагдсанаар хүчин төгөлдөр бус болсон байна.
- 28) ХХААХҮ-ийн сайд, Сангийн сайдын 2010 онд хамтран баталсан “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгох журам” нь ЗГ-ын 2009 оны 350 дугаар тогтоолыг үндэслэн баталсан байх бөгөөд тус тогтоолыг ЗГ-ын 2012 оны 77 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна. ЗГ-ын 350 дугаар тогтоол хүчингүй болсноор “Хүнсний буудайнд урамшуулал олгох тухай журам” хүчингүй болсон бөгөөд журмыг шинэчлэн батлуулаагүй буюу 2012 оноос хойш хүчингүй болсон журмын хүрээнд ажиллаж ирсэн байна.
- 29) Тариаланг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагаа болох санхүүгийн дэмжлэг буюу хүүгүй зээлдүүлэх үйл ажиллагаанд баримтлах журам, гарын авлага байхгүй бөгөөд, хүчингүй болсон журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

1. Тариаланг дэмжих сангаас 2005-2018 оны хооронд нийт 350.2 тэрбум төгрөгийн худалдан авалтийг хийсэн бөгөөд үүний 17.3 хувийг ТЭДСангаас хийсэн худалдан авалт, 16.5 хувийг ХХААХҮЯ-наас хийсэн худалдан авалт, 16.1 хувийг үрийн буудайн худалдан авалт, үлдсэн 50 орчим хувийг хүнсний улаанбуудайн худалдан авалт эзэлж байна. ХХААХҮЯ болон ТЭДСангаас зохион байгуулсан нийт 118.7 тэрбум төгрөгийн худалдан авалтын 46.9 тэрбум төгрөгийн гэрээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчиж хийгдсэн байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зохион байгуулсан тендер шалгаруулалтад тендерийн баримт бичигт заасан эрх бүхий байх, ажлын туршлага, санхүүгийн чадварын шалгуур, техникийн тодорхойлолтын нөхцөл, шаардлагыг хангахгүй тендерт оролцогчийг шалгаруулж, гэрээ байгуулсан нийтлэг зөрчил байна. Мөн Сангийн яамнаас хүргүүлсэн тендер шалгаруулалттай холбогдох зөрчил арилгах мэдэгдлийн дагуу арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Тус яамны зохион байгуулсан тендер шалгаруулалтуудад тендерийн урилга зарласан өдрөөс нээлт хийх өдөр хүртэлх хугацаа, тендерийн баталгааны хугацаа, гэрээ байгуулах эрх олгосон өдрөөс гэрээ байгуулсан өдрийн хугацааг Иргэний хуулийн 72 дугаар зүйлийн 72.6-д заасан журмын дагуу тооцоогүй, дутуу тооцсон нийтлэг зөрчил байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 болон 8 дугаар зүйлийн 8.4-т заасныг баримтлаагүй, тендер шалгаруулалтын журмыг буруу сонгосон зөрчил нийтлэг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Тариалан эрхлэлтийг дэмжих санд худалдан авах ажиллагааны талаарх нэгдсэн мэдээлэл бүртгэл байхгүй, хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-т заасны дагуу архивын хавтаст хэргийн бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллаагүй, гэрээ байгуулах эрх олгосон оролцогчдоос гүйцэтгэлийн баталгаа шаардадгүй, гүйцэтгэлийн баталгаа шаардсан хэдий ч гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгүүлээгүй зөрчлүүд нийтлэг байна.

Иймд тус сан болон салбарын яамнаас хийгдэж буй худалдан авах ажиллагааны хяналт, хэрэгжилтийг сайжруулах, хуулийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажилладаг болоход анхаарах зайлшгүй шаардлага байна.

2. Тариаланг дэмжих сангаас 2005-2018 оны хооронд 157.4 тэрбум төгрөгийн буудайн урамшууллыг давхардсан тоогоор 7500 орчим ААН, иргэнд олгосон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 350 дугаар тогтоолыг үндэслэн ХХААХҮ сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 24/34 тоот тушаалаар баталсан “Хүнсний буудайнд мөнгөн урамшуулал олгоход баримтлах журам”-ыг баримтлан ажиллаж ирсэн байна. Гэвч, тус журмыг гаргахдаа үндэслэсэн 2009 оны 350 дугаар тогтоолыг 2012 оны 77 дугаар ЗГ-ын тогтоолоор хүчингүй болгосон байх бөгөөд үүнтэй холбоотойгоор тус журмыг шинэчлэн батлаагүй бөгөөд, 2012 оноос хойш хүчингүй болсон журмыг баримтлан тариаланчдад урамшуулал олгох үйл ажиллагааг зохион байгуулан ажиллажээ.

Урамшуулал авсан ААН, иргэдийн мэдээллээс харахад улаанбуудай тарьсан ААН-үүд нь өөрсдийн гурилын үйлдвэрт 2013-2017 оны хооронд 38.1 мянган тонн улаанбуудай нийлүүлж 2.7 тэрбум төгрөгийн урамшууллыг авсан байна. Тус аж ахуйн нэгжүүдийн өөрийн гурилын үйлдвэртээ тушаасан улаанбуудайн хэмжээг тогтоохдоо зөвхөн толгой компаний захирал болон тариалангын бригадын дарга /нэг компанийн ажилтан хооронд/ хооронд байгуулсан гэрээг үндэслэн урамшууллын хэмжээг тогтоосон байна. Тус сангийн ажилтнууд нь урамшуулал авахаар хүсэлтээ ирүүлсэн ААН-үүдийн мэдээллийг зөвхөн гурилын үйлдвэртэй тооцоо нийлсэн акт, байгуулсан гэрээгээр баталгаажуулж байгаа нь урамшууллыг хуурамч материал бүрдүүлэн авах, ААН-үүд өөрсдийн гурилын үйлдвэрт нийлүүлсэн буудайн хэмжээг хуурамчаар өсгөж урамшуулал авах өндөр эрсдэлтэй байна.

Түүнчлэн урамшууллыг олгохдоо тус сан нь өртэй ААН-үүдийн өрийг өгөх урамшууллаас суутган тооцдог байна. Урамшуулал авахад бүрдүүлэх материалын жагсаалтад татварын албаны тодорхойлолтыг авсан байх бөгөөд, үүнийг урамшууллын шалгуур үзүүлэлт болгон үнэлхэд ашигладаггүй байна. Иймд хүчингүй болсон журмыг шинэчлэн батлуулахдаа, татварын өртэй ААН урамшуулал авах тохиолдолд татварын өрийг суутган тооцох тогтолцоог бүрдүүлэн ажиллах шаардлагатай байна.

ХХААХҮСайдын тушаалуудаар сангийн хөрөнгөөр худалдан авсан хүнсний улаан буудайн үнийг жил бүр шинэчлэн тогтоож худалдан борлуулах арга хэмжээ авч байгаа боловч буудайн худалдан борлуулах үнийг худалдан авах үнээс доогуур тогтоодгоос үүссэн тооцооны зөрүүг актаар баталгаажуулж харилцагч тус бүрээр

тооцоо хийгээгүй, өр авлагаа нэмэгдүүлсэн, сангаас олгож байгаа санхүүжилтийн гүйцэтгэлийг бодит үр дүнтэй нь уялдуулан тооцож шинжилгээ дүгнэлт гаргаагүй, сангийн хөрөнгийн зарцуулалтанд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй, анхан шатны баримтыг зохих журмын дагуу хөтлөөгүй, нягтлан бодох бүртгэлийн журнал, ерөнхий дэвтрийн тоон үзүүлэлт зөрүүтэй илэрхийлэгдсэн зэргээр хууль тогтоомжийг зөрчсөн байна.

3. Тариаланг дэмжих сангаас 2005-2018 оны хооронд нийт 585.3 тэрбум төгрөгийн үндсэн дэмжлэгийг тариалан эрхлэгч иргэд ААН-д олгож, 157.4 тэрбум төгрөгийн урамшууллыг олгосон байна. 2018 оны 9 дүгээр сарын 31-ний байдлаар тус сангийн нийт өглөг 141.1 тэрбум төгрөг, авлага 131.9 тэрбум төгрөг байгаагаас хугацаа хэтэрсэн найдваргүй зээл **72.1** тэрбум төгрөг байна. Тус сан болон салбарын яамнаас хийсэн худалдан авах ажиллагаа ихээхэн хэмжээний зөрчилтэй бөгөөд, буудайн урамшуулал олгох, өр суутган тооцох, хяналтын хариуцлагын тогтолцоо сул байна.

Түүнчлэн сангаас олгож байгаа үндсэн дэмжлэгийн олгох, түүнд хяналт тавих, эргэн төлүүлэх тогтолцоо муу, олгож буй дэмжлэгүүд хоорондын уялдаа холбоогүй байна.

Иймд тус сангаар дамжуулан олгож буй дэмжлэг, урамшууллын тогтолцоог шинэчлэн зохион байгуулж, үр ашгийг нэмэгдүүлэх, хугацаа хэтэрсэн өглөг, авлагыг түргэн шуурхай барагдуулах зайлшгүй шаардлагатай байна.

4. Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь Засгийн газрын тусгай сангийн тухай, Тариалангын тухай хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Гэсэн хэдий үйл ажиллагаанд гол мөрдлөг болгон ажилладаг “Хүнсний буудайнд урамшуулал олгох тухай журам”, “Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Тариаланг дэмжих сангийн дүрэм” зэрэг нь 2006 онд батлагдсан Тариалангын тухай хууль хууль, ЗГ-ыг тогтоол хүчингүй болсноор хүчин төгөлдөр бус болсон байх бөгөөд өнөөдрийг хүртэл тус журам, дүрмүүдийг шинэчлэн батлуулаагүй байгаа нь сангийн үйл ажиллагааг эрсдэлд оруулж байна.

Түүнчлэн Тариаланг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагаа болох санхүүгийн дэмжлэг буюу хүүгүй зээлдүүлэх үйл ажиллагаанд баримтлах журам, гарын авлага байхгүй бөгөөд, хүчингүй болсон журмуудыг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тариаланг дэмжих санд буудай худалдан авах, зарах үнийг салбарын сайдын тушаалаар тогтоож ирсэн байх бөгөөд ингэхдээ буудайн зарах үнийг худалдан авсан үнээс багаар тогтоосноос үүдэн ТЭД сан нь алдагдал хүлээж ирсэн байна.